



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: САГ-2021/24/СТА-ТЕЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2021 он

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч,  
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын дөрөвдүгээр газрын захирал,  
Тэргүүлэх аудитор: Я.Самбууням

Утас: 264909

Цахим хаяг: [sambuunyamy@audit.gov.mn](mailto:sambuunyamy@audit.gov.mn)

Аудитын менежер: С.Нацагдорж

Утас: 261805

Цахим хаяг: [natsagdorjs@audit.gov.mn](mailto:natsagdorjs@audit.gov.mn)

Аудитор: Д.Болор-Эрдэнэ

Утас: 261628

Цахим хаяг: [bolor-erdened@audit.gov.mn](mailto:bolor-erdened@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл .....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал .....	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	14
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	14
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт .....	15
3.5.3 Авлага .....	15
3.5.4 Урьдчилгаа .....	16
3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт .....	17
3.5.6 Бараа материал .....	18
3.5.7 Үндсэн хөрөнгө .....	19
3.5.8 Өр төлбөр .....	19
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо .....	20
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	21
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	23
3.8 Аудитын гол асуудал.....	23
3.9 Шилэн дансны мэдээлэл.....	24
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	24
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал .....	24
4. Аудитын илрүүлэлт .....	27
Залруулсан алдаа .....	27
Төлбөрийн акт .....	27
Албан шаардлага: .....	27
Зөвлөмж.....	29
5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд аудит хийх хугацаанд түүвэрт хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчил .....	29
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	32
7. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт .....	33

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АТҮТ	Автотээврийн үндэсний төв
АТТ	Авто тээврийн төв
АХБ	Азийн хөгжлийн банк
АЗЗА	Авто зам засвар арчлалт
АЗННС	Авто замын норм нормативын сан
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГТХЗНТ	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ЗТХТ	Зам, тээврийн хөгжлийн төв
МТЗ	Монголын төмөр зам
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
ОУНБ	Олон Улсын нисэх буудал
СХД	Сонгино хайрхан дүүрэг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТХҮТ	Техник хяналтын үйлчилгээний төв
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХШУДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ХК	Хувьцаат компани
УОК	Улсын онцгой комисс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
УИХ	Улсын Их хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ИНҮТ	Иргэний нисэхийн үндэсний төв



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2021.04.26 № 1332

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын санал дүгнэлт

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 39,457.0 сая төгрөгийн залруулаагүй алдаа зөрчил илэрсэн буюу бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн, УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал", "Эрх ба үүрэг" "Тохиолдсон байх", "Оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,878,974,183.1	2,545,524,247.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	355,052,256.4	185,058,585.0
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	34,147,418.0	7,961,703.8
33	АВЛАГА	133,212,962.3	117,582,659.8
34	УРЬДЧИЛГАА	228,789,276.0	168,414,091.2
35	БАРАА МАТЕРИАЛ	556,801,598.2	950,047,478.0
36	НӨӨЦИЙН БАРАА	803.9	803.9
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	570,969,868.2	1,116,458,925.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,255,084,391.0	6,439,523,011.6
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	35,535,444.1	511,880,490.5
37200	Үнэт цаас	191,192.0	463,419,322.6
37300	Урт хугацаат зээл	35,344,252.1	48,461,168.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,219,548,946.9	5,927,642,521.1
39100	Газар	0.0	13,376,866.0
39200	Биет хөрөнгө	5,441,846,810.8	5,180,422,651.8
39300	Биет бус хөрөнгө	765,074,362.2	719,803,003.8
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	12,627,773.8	14,039,999.5
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>8,134,058,574.1</b>	<b>8,985,047,259.0</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	903,482,361.5	1,851,676,559.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	214,473,955.5	411,873,971.2
41200	Богино хугацаат зээлийн өглөг	48,707,056.2	52,785,333.0
41300	Өглөг	133,392,965.7	343,302,164.8
41400	Урьдчилж орсон орлого	32,373,933.6	15,786,473.5
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	689,008,406.0	1,439,802,588.7
42100	Урт хугацаат үнэт цаас	357,000,000.0	882,950,000.0
42200	Урт хугацаат зээл	332,008,406.0	556,852,588.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,230,576,212.6	7,133,370,699.1
51	Засгийн газрын хувь оролцоо	7,230,576,212.6	7,133,370,699.1
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,251,088,730.4	2,244,144,809.2
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	40,224,317.0	40,714,659.6
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	532,881.2	532,881.2
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	2,603,255.2	2,005,913.5
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	850,051,138.2	621,991,471.9
51200	Хуримтлагдсан үр дүн	1,830,473,125.6	1,968,030,005.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,255,489,414.3	2,255,837,608.1
52	Хяналтын бус хувь оролцоо	113,350.6	113,350.6
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>8,134,058,574.1</b>	<b>8,985,047,259.0</b>

## 2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>691,835,784.0</b>	<b>1,064,000,812.8</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	455,509,540.2	818,252,331.9
120	Нийтлэг татварын бус орлого	455,509,540.2	818,252,331.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	236,326,243.8	245,748,481.0
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>790,942,592.9</b>	<b>682,326,908.2</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	790,942,592.9	666,134,224.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	786,457,261.0	585,492,606.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,874,029.2	6,073,030.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	614,869.5	766,037.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	217,722.9	235,523.4
2104	Хангамж, бараа материалын зардал	272,615.9	300,066.6
2105	Норматив зардал	4,765.5	60,942.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	169,918.3	142,116.8
2107	Томилолт, зочны зардал	250,542.6	96,406.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	288,509,326.3	98,129,117.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	491,543,470.9	479,689,365.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,485,331.9	80,641,617.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	16,192,683.7
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(99,106,808.9)</b>	<b>381,673,904.6</b>
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,491,054.5	2,835,421.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	37,476,378.7	69,230,735.1
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(134,092,133.1)</b>	<b>315,278,590.6</b>

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>7,879,778,544.8</b>	<b>7,879,778,544.8</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,790,027,284.4)	(1,790,027,284.4)
<b>3</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>6,089,751,260.4</b>	<b>6,089,751,260.4</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(772.6)	(772.6)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,260,138,570.5	1,260,138,570.5
7	Өмчид гарсан өөрчлөлт	22,639,882.4	22,639,882.4
8	Зарласан ногдол ашиг	(7,860,595.1)	(7,860,595.1)
9	Тайлант үеийн үр дүн	(134,092,133.1)	(134,092,133.1)
<b>10</b>	<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>7,230,576,212.6</b>	<b>7,230,576,212.6</b>
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(176,395,867.4)	(176,395,867.4)
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,054,180,345.3	7,054,180,345.3
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	351,038.5	351,038.5
14	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(230,640,098.1)	(230,640,098.1)
15	Өмчид гарсан өөрчлөлт	3,145,024.1	3,145,024.1
16	Зарласан ногдол ашиг	(692,460.9)	(692,460.9)
17	Тайлант үеийн үр дүн	315,278,590.6	315,278,590.6
<b>18</b>	<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>7,133,370,699.1</b>	<b>7,133,370,699.1</b>



## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,275,548,252.6</b>	<b>750,884,951.4</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,060.0	-
110	Орлогын албан татвар	1,060.0	-
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,060.0	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,039,220,032.0	503,625,777.4
120	Нийтлэг татварын бус орлого	1,039,220,032.0	503,612,477.4
121	Хөрөнгийн орлого	-	13,300.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	236,327,160.7	247,259,173.9
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>921,245,857.1</b>	<b>500,597,746.2</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	921,245,857.1	500,597,746.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	752,225,813.0	411,107,200.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	141,694,081.8	143,753,650.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,072,359.7	18,894,691.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,446,099.0	8,260,168.1
2104	Хангамж, бараа материалын зардал	185,629,269.8	68,776,750.3
2105	Норматив зардал	165,475.9	231,637.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,129,665.9	6,191,381.2
2107	Томилолт, зочны зардал	1,368,068.0	780,161.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	369,099,439.9	162,667,336.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,621,353.0	1,551,424.9
212	ТАТААС	192,463.3	350,852.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	168,827,580.8	89,139,693.3
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>354,302,395.5</b>	<b>250,287,205.2</b>
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	19,077,880.7	30,415,594.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	497,399,580.2	960,282,985.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	497,399,580.2	960,282,985.0
2200	Дотоод эх үүсвэрээр	497,399,580.2	960,282,985.0
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(478,321,699.6)</b>	<b>(929,867,390.6)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>326,368,334.6</b>	<b>509,586,513.9</b>
14	Бусад эх үүсвэр	377,025,808.1	547,391,403.4
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	50,657,473.5	37,804,889.5
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>202,349,030.5</b>	<b>(169,993,671.5)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	152,703,225.9	355,052,256.4
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	355,052,256.4	185,058,585.0

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>279,244,368,000.00</b>	<b>253,959,160,895.00</b>	<b>25,285,207,105.00</b>	<b>90.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>12,056,884,800.00</b>	<b>11,645,258,339.30</b>	<b>411,626,460.70</b>	<b>96.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>11,674,581,200.00</b>	<b>11,357,174,618.30</b>	<b>317,406,581.70</b>	<b>97.3</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>6,425,837,800.00</b>	<b>6,411,049,637.61</b>	<b>14,788,162.39</b>	<b>99.8</b>
210101	Үндсэн цалин	5,043,140,500.00	4,860,534,843.28	182,605,656.72	96.4
210102	Нэмэгдэл	1,059,355,100.00	1,183,316,594.33	(123,961,494.33)	111.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	323,342,200.00	367,198,200.00	(43,856,000.00)	113.6
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>867,488,100.00</b>	<b>834,696,550.99</b>	<b>32,791,549.01</b>	<b>96.2</b>
210201	Тэтгэврийн даатгал	610,454,600.00	606,645,461.69	3,809,138.31	99.4
210202	Тэтгэмжийн даатгал	64,258,300.00	57,204,253.09	7,054,046.91	89.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	51,406,700.00	43,169,129.85	8,237,570.15	84.0
210204	Ажилгүйдлийн даатгал	12,851,600.00	12,540,951.75	310,648.25	97.6
210205	Эрүүл мэндийн даатгал	128,516,900.00	115,136,754.61	13,380,145.39	89.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>209,318,500.00</b>	<b>209,318,500.00</b>	-	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	27,848,400.00	27,848,400.00	-	100.0
210302	Түлш, халаалт	39,847,500.00	39,847,500.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	19,800,000.00	19,800,000.00	-	100.0
210304	Байрны түрээс	121,822,600.00	121,822,600.00	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>190,428,000.00</b>	<b>178,386,390.41</b>	<b>12,041,609.59</b>	<b>93.7</b>
210401	Бичиг хэрэг	54,334,300.00	47,039,741.00	7,294,559.00	86.6
210402	Тээвэр, шатахуун	26,778,500.00	26,214,100.00	564,400.00	97.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	38,297,500.00	38,061,130.41	236,369.59	99.4
210404	Ном, хэвлэл	4,262,100.00	4,262,100.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	66,755,600.00	62,809,319.00	3,946,281.00	94.1
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>11,633,000.00</b>	<b>11,584,000.00</b>	<b>49,000.00</b>	<b>99.6</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,633,000.00	11,584,000.00	49,000.00	99.6
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>66,612,900.00</b>	<b>66,610,679.00</b>	<b>2,221.00</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,250,400.00	37,795,819.00	(15,545,419.00)	169.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,335,600.00	5,335,200.00	400.00	100.0
210604	Урсгал засвар	39,026,900.00	23,479,660.00	15,547,240.00	60.2
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>88,705,800.00</b>	<b>80,158,323.00</b>	<b>8,547,477.00</b>	<b>90.4</b>
210702	Дотоод албан томилолт	88,705,800.00	80,158,323.00	8,547,477.00	90.4
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,751,840,200.00</b>	<b>3,551,039,942.49</b>	<b>200,800,257.51</b>	<b>94.6</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,387,206,500.00	3,204,722,096.76	182,484,403.24	94.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	18,785,000.00	2,765,000.00	16,020,000.00	14.7
210803	Даатгалын үйлчилгээ	13,153,000.00	13,107,840.00	45,160.00	99.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,589,000.00	935,668.00	653,332.00	58.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	295,800.00	140,800.00	155,000.00	47.6

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	98,117,900.00	97,693,662.73	424,237.27	99.6
210807	Газрын төлбөр	3,023,500.00	2,862,540.00	160,960.00	94.7
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	399,700.00	50,000.00	349,700.00	12.5
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	229,269,800.00	228,762,335.00	507,465.00	99.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>62,716,900.00</b>	<b>14,330,594.80</b>	<b>48,386,305.20</b>	<b>22.8</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,230,000.00	-	1,230,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	61,486,900.00	14,330,594.80	47,156,305.20	23.3
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>382,303,600.00</b>	<b>288,083,721.00</b>	<b>94,219,879.00</b>	<b>75.4</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>182,595,000.00</b>	<b>180,151,488.00</b>	<b>2,443,512.00</b>	<b>98.7</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	182,595,000.00	180,151,488.00	2,443,512.00	98.7
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>199,708,600.00</b>	<b>107,932,233.00</b>	<b>91,776,367.00</b>	<b>54.0</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	64,174,500.00	58,105,273.00	6,069,227.00	90.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	135,534,100.00	49,826,960.00	85,707,140.00	36.8
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>267,187,483,200.00</b>	<b>242,313,902,555.70</b>	<b>24,873,580,644.30</b>	<b>90.7</b>
220001	Барилга байгууламж	190,489,089,500.00	173,991,248,405.00	16,497,841,095.00	91.3
221001	Их засвар	18,898,393,700.00	16,911,471,390.00	1,986,922,310.00	89.5
223001	Бусад хөрөнгө	57,800,000,000.00	51,411,182,760.70	6,388,817,239.30	88.9
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>279,244,368,000.00</b>	<b>254,124,890,530.46</b>	<b>25,119,477,469.54</b>	<b>91.0</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>264,244,368,000.00</b>	<b>245,476,884,817.54</b>	<b>18,767,483,182.46</b>	<b>92.9</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	264,244,368,000.00	245,476,884,817.54	18,767,483,182.46	92.9
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>15,000,000,000.00</b>	<b>8,648,005,712.92</b>	<b>6,351,994,287.08</b>	<b>57.7</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000,000.00	8,648,005,712.92	6,351,994,287.08	57.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,730,695.00	(2,730,695.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	19,600.00	(19,600.00)	-
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>3</b>	<b>3</b>	-	-
610001	Төсвийн байгууллага	3	3	-	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>276</b>	<b>280</b>	(4)	-
620001	Удирдах ажилтан	12	12	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	256	260	(4)	-
620003	Үйлчлэх ажилтан	8	8	-	-
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>276</b>	<b>280</b>	(4)	-
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	155	159	(4)	-
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	4	4	-	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11	-	-
650013	УТҮГ	106	106	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>125,392.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>125,392.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>125,392.0</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,600.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,600.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>101,792.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	101,792.0
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>101,792.0</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>101,792.0</b>
131103	ЗГНХ,ЗДНХ,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,792.0
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>(23,600.0)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>250,150.3</b>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>226,550.3</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитор Д.Болор-Эрдэнэ нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, Тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 03/1348 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь эдийн засгийн өсөлтийг хангах, зам, тээвэр, логистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээний нөхцөлийг бий болгох явдал юм.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод зам, тээврийн салбарт 2020-2050 оны урт хугацаанд баримтлах бодлогыг 3 үе шаттайгаар боловсруулж тусгуулсан, мөн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг боловсруулан ажилласан байна. Тухайлбал:

- Зам, тээврийн салбарын хөгжлийн нэгдсэн болон хүний нөөцийн бодлого, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, салбар хоорондын уялдаа холбоог хангах, үйл ажиллагааг зохицуулах, төсөв төлөвлөх, хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, салбарын стандарт, норм, норматив, техник, технологи, судалгаа шинжилгээг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хөтөлбөр боловсруулах, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Авто замын салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

- Төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Иргэний нисэхийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Зам, тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын “Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай” 187 дугаар тогтоол;
- Засгийн газрын “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 78 дугаар тогтоол;
- Засгийн газрын “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоол;
- Засгийн газрын “Коронавируст халдвар (Covid-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” 168 дугаар тогтоол;
- Засгийн газрын “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 183 дугаар тогтоол тус тус батлагдан гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө бага гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2020 онд харьяа байгууллага, төсөл хөтөлбөрийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт 7 газрыг бүрэн хамруулан, 80.0 сая төгрөгийн 3 албан шаардлага, 22 зөвлөмж хүргүүлж, хэрэгжилт 85.5 хувьтай байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал**

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг

зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн үйл ажиллагааны зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн үйл ажиллагааны зардал 706,467.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,064.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны залруулга хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 751,557.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,515.6 сая төгрөгөөр тогтоов.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 355,052.2 сая, эцсийн үлдэгдэл 185,058.6 сая төгрөг болж, 169,993.6 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	253.3	215.6	(37.7)	0.1
Банканд байгаа бэлэн мөнгө	354,794.8	184,841.3	(169,953.5)	99.9
Замд яваа мөнгөн хөрөнгө	4.1	1.7	(2.4)	-
<b>Дүн</b>	<b>355,052.2</b>	<b>185,058.6</b>	<b>(169,993.6)</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хөрөнгө оруулалтын ажлын барьцаа 32,255.4 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 100,802.3 сая төгрөг арилжааны банкны дансанд, 51,783.5 сая төгрөг валютын дансанд байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд “Буянт-Ухаа” ОУНБ-ын ачаа тээврийн хадгалалтын болон зоогийн газрын орлоготой холбоотой 1.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө байна.

Мөнгөн хөрөнгийн дансны бууралт нь “Монголын төмөр зам” ТӨХК-д хэрэгжиж буй “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төсөл”-ийн ажил эрчимжиж, тайлант оны гэрээт ажлын гүйцэтгэлд төлөлт хийж зарцуулсантай холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт:*

*-Дууссан ажлын үлдэгдэл 346.0 сая, түрээсийн орлого 310.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй; /ЗТХЯ 346.0 сая, МТЗ ТӨХК 310.0 сая, Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудал 0.3 сая төгрөг/*

*-ЗТХЯ улсын тэмдэгтийн хураамжийн 1,305.5 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй;*

*-Шүүхийн шийдвэрээр нийт 199.1 сая төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий ажилтанд олгосон; /ЗТХЯ 30.3 сая, ИНЕГ 82.2 сая, ИНУТ 31.4 сая, МИАТ ТӨХК 34.5 сая, Баянхонгор аймгийн нисэх буудал 1.1 сая, АТҮТ ТӨҮГ 19.6 сая төгрөг/*

-Мөнгөн хөрөнгөөс зориулалт бус, тушаал шийдвэргүй 768.0 сая төгрөгийг зарцуулсан; /Сэргээн засах амралтын газар 10.1 сая, “Булган АЗЗА” ТӨХК 374.5 сая, “Төв АЗЗА” ТӨХК 3.8 сая, ЗТХЯ 18.3 сая, МИАТ ТӨХК 244.6 сая, АТҮТ ТӨҮГ 116.6 сая төгрөг/

- ЗТХЯ шагнал урамшууллыг хавтгайруулан олгосон 159.4 сая, АТҮТ ТӨҮГ гэрээт ажилтанд 303.8 сая төгрөг олгосон;

-АТҮТ ТӨҮГ эрсдэлтэй арилжааны банканд 277.0 сая төгрөг байршуулсан байна.

### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 34,147.4 сая, эцсийн үлдэгдэл 7,961.7 сая төгрөг болж, 26,185.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Богино хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагаар /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Үнэт цаас/Хадгаламж	34,147.4	7,961.7	(26,185.7)
<b>Дүн</b>	<b>34,147.4</b>	<b>7,961.7</b>	<b>(26,185.7)</b>

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Арилжааны банкин дахь мөнгөн хадгаламж буюу Голомт банкны богино хугацаат хадгаламжийн данснаас үйл ажиллагааны зардалд татан авалт хийснээр МИАТ ТӨХК-ийн үлдэгдэл 7,961.7 сая төгрөг байршиж байна.

### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 133,213.0 сая, эцсийн үлдэгдэл 117,582.7 сая төгрөг болж, 15,630.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	94.6	85.8	(8.8)
Төлбөртэй үйлчилгээний авлага	43,823.2	35,381.6	(8,441.6)
Татаас, санхүүжилтийн авлага	1,510.7	2,528.1	1,017.4
Татвар, НДШ-ийн авлага	17,933.8	18,897.8	964.0
Дансны авлага /ТӨҮГ/	32,637.8	27,161.2	(5,476.6)
Бусад авлага	37,212.9	33,528.2	(3,684.7)
<b>Дүн</b>	<b>133,213.0</b>	<b>117,582.7</b>	<b>(15,630.3)</b>

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 23,778.2 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- ИНЕГ-т гадаадын авиа компани дампуурсан, дотоодын авиа компаниудын үйл ажиллагаа доголдсон зэргээс үүссэн тооцоо нийлсэн актгүй навигацийн төлбөр нийт 16,057.9 сая төгрөгийн авлага;
- МИАТ ТӨХК-д агаарын тээврийн зорчигчийн тийз борлуулалтын үйл ажиллагаа, газрын үйлчилгээ, ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтээс үүссэн эзэн холбогдогч хаяг байршил тодорхойгүй, авлага барагдуулалт удаашралтай 6,804.2 сая төгрөгийн авлага;
- МТЗ ТӨХК-д 2-5 жилийн насжилттай шүүхээр шийдвэрлүүлж, биелэлтийг хангахаар хариуцагч байгууллагатай эвлэрлийн гэрээ байгуулан ажиллаж байгаа хэдий ч авлага барагдуулалт удаашралтай 514.5 сая төгрөгийн авлага;



- ЗТХЯ-ны хөрөнгө оруулалтын дансанд Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны /хуучнаар/ балансаас шилжиж ирсэн хугацаа хэтэрсэн, тооцоо нийлсэн актгүй 229.3 сая төгрөгийн авлага;
- “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-д тооцооны зөрүү, гэрээ байгуулалгүй ажил гүйцэтгэснээс үүссэн 104.9 сая төгрөгийг авлага;
- ЗТХТ ТӨҮГ-т ТӨБЗГ-ын 2018 оны 289 дүгээр тогтоолоор “Автозамын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК татан буугдсантай холбоотой он дамжсан барагдах боломжгүй авлагыг бүртгэсэнтэй холбоотой 67.4 сая төгрөгийн авлага тус тус эзэлж байгаа нь улсын төсвийн орлогыг дутуу төвлөрүүлэх, мөн орлогын эх үүсвэр бүрдэхгүй байх үр дагавартай байна.

ИНЕГ-ын 2018, 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар Үндэсний аудитын газраас гадаадын дампуурсан авиа компаниуд болон дотоодын авиа компаниудаас авах авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах 2019 оны 02/190, 2020 оны 01/200 дугаартай албан шаардлага, мөн МИАТ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Катерингийн төвийн удирдах үйл ажиллагааг гүйцэтгэх удирдлага”-ын гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах 2020 оны 01/113 дугаар албан шаардлага өгснийг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Аудитын илрүүлэлт:**

-Олон жилийн насжилттай 8,414.3 сая төгрөгийн авлагыг барагдуулж ажиллаагүй;  
 /ИНЕГ 2,477.0 сая, ИНҮТ 9.7 сая, Сэргээн засах амралтын газрын 11.1 сая, МИАТ ТӨХК 5,827.7 сая, АТҮТ ТӨҮГ 4.7 сая, “Харгуй” ТӨХК 84.1 сая төгрөг/  
 -Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 1,325.8 сая төгрөгийн авлага;  
 /Сэргээн засах амралтын газар 9.7 сая, “Баянт-Ухаа” ОУНБ-ын 57.4, МТЗ ТӨХК 6.4 сая, ЗТХЯ-Хөрөнгө оруулалт 229.3 сая, МИАТ ТӨХК 1,002.0 сая, СХД-ийн Зорчигч тээврийн төв 21.0 сая төгрөг/  
 -Хувь хүнээс болон ажилчдаас авах 301.1 сая төгрөгийн авлагыг барагдуулж ажиллаагүй; /Баянхонгор аймгийн нисэх буудал 2.9 сая, МИАТ ТӨХК 139.6 сая, АТҮТ ТӨҮГ 51.5 сая, ИНЕГ 107.1 төгрөг/  
 -МИАТ ТӨХК 72.7 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

**3.5.4 Урьдчилгаа**

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 228,789.3 сая, эцсийн үлдэгдэл 168,414.1 сая төгрөг болж, 60,375.2 сая төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт №4. Урьдчилгаа дансны үлдэгдэл**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	228,217.8	168,339.5	(59,878.3)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	9.4	74.6	65.2
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	562.1	-	(562.1)
<b>Дүн</b>	<b>228,789.3</b>	<b>168,414.1</b>	<b>(60,375.2)</b>

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл 60,375.2 сая төгрөгөөр буурсан нь МТЗ ТӨХК-ийн “Тавантолгой-Зүүн баян чиглэлийн төмөр зам барих төсөл”-ийн урьдчилж гарсан зардалд бүртгэлтэй 38,265.6 сая төгрөгийн гэрээт ажил, 892.8 сая төгрөгийн барилгын зураг төсөл зохиох ажлын гүйцэтгэлийг тус тус хангаж, дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд бүртгэсэн, “Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр зам барих төсөл”-ийн 21,192.4 сая төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2020 оны 02 дугаар тогтоолоор “Тавантолгой төмөр зам” ТӨХК-д балансаас балансад шилжүүлсэн, төслийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 252.3 сая төгрөгийг дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд хуримтлуулан бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2018-2020 онд үүссэн 55,817.9 сая төгрөгийн урьдчилж олгосон бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. Үүнд:

- МИАТ ТӨХК-ийн урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 8,789.9 сая төгрөг нь Wells Fargo Bank Northwest, National Association банкнаас авсан зээлд UMB Bank, N.A байршуулсан барьцаа 6,190.0 сая төгрөг, техник үйлчилгээний барьцаа, агаарын хөлгийн сэлбэгийн тээвэрлэлтийн урьдчилгаа 947.9 сая төгрөг, агаарын хөлгийн даатгал, нисэх бүрэлдэхүүний амь насны даатгалын урьдчилгаа 858.3 сая төгрөг болон ажилтан албан хаагчдын дараа тооцоо, авто зогсоолын урьдчилгаа 793.7 сая төгрөгийг бүртгэсэн;
- Улсын авто замын сангийн урьдчилгаа дансны үлдэгдэлд замын сангийн хөрөнгөөр шинээр 8 төлбөр авах цэг барих, зураг төслийг шинэчлэн боловсруулах, 4 төлбөр авах цэгт авто пүү суурилуулах, Налайх-Тэрэлжийн төлбөр авах цэгийг өргөтгөх зэрэг гэрээт ажлын урьдчилгаа 4,464.3 сая төгрөг олгосон;
- МТЗ ТӨХК-ийн урьдчилгаа дансны үлдэгдэлд “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төсөл”-ийн урьдчилж гарсан зардалд бүртгэлтэй 38,265.6 сая төгрөгийн гэрээт ажил, 892.8 сая төгрөгийн барилгын зураг төсөл зохиох ажлын гүйцэтгэлийг хангаж дуусаагүй;
- ИНЕГ-ын урьдчилгаа дансны үлдэгдэлд бараа ажил, үйлчилгээнд нормын хувцас хэрэглэлийн 11.1 сая, он дамжсан даатгалын үйлчилгээний төлбөрт 293.0 сая төгрөг;
- ЗТХЯ-ны хөрөнгө оруулалтын санхүүжилтээр Монгол Улсын Засгийн газар болон Беларус Улсын Засгийн газар хооронд 2019 онд байгуулсан хөнгөлөлттэй зээлийн ерөнхий гэрээний хүрээнд автозамын засвар арчлалтын 42 машин худалдан авах гэрээний урьдчилгаа төлбөр 1,684.4 сая төгрөг;
- АТҮТ ТӨҮГ-ын урьдчилгаа дансны үлдэгдэлд Баянхонгор аймгийн Авто тээврийн төвийн барилгын урьдчилгаа санхүүжилт 990.0 сая, зураг төслийн 88.9 сая, дуудлага худалдааны программын 9.9 сая, шатахууны урьдчилгаа 32.7 сая төгрөг;
- “Дорноговь АЗЗА” ТӨХК-д бүртгэлтэй 220.6 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт нь Цагаан хаалганы автозамын зогсоолын өргөтгөлийн ажлыг эхлүүлсэнтэй холбоотой;
- ЗТХТ ТӨҮГ-ын урьдчилгаа дансны үлдэгдэлд 2021 оны ногдол ашгийн урьдчилгаанд 45.0 сая төгрөг, ариутгалын тоног төхөөрөмж болон программ хөгжүүлэлтийн гэрээт ажлын эхний санхүүжилтэд 7.2 сая төгрөг;
- “Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХК-ийн ашиглалтын зардалтай холбоотой түрээс, интернэтийн үйлчилгээний барьцаанд 9.4 сая, санхүүгийн тайлангийн аудитын төлбөр болон даатгал, шатахууны картын урьдчилгаанд 13.1 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрүүд тус тус эзэлж байна.

*Аудитын илрүүлэлт:*

*-МТЗ ТӨХК урьдчилгаа дансны үлдэгдлийг 2,411.7 сая төгрөгөөр зөрүүтэй баталгаажуулсан, сөрөг утгатай 264.6 сая төгрөг бүртгэлтэй байна.*

### 3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын эхний үлдэгдэл 35,535.4 сая, эцсийн үлдэгдэл 511,880.4 сая төгрөг болж, 476,345.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №5. Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Үнэт цаас	191.2	463,419.3	463,228.1
Урт хугацаат зээл	35,344.2	48,461.2	13,117.0
<b>Дүн</b>	<b>35,535.4</b>	<b>511,880.5</b>	<b>476,345.1</b>

*Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлд:

- “Монголын төмөр зам” ТӨХК нь ТӨБЗГ-ын 2020 оны 02 дугаар тогтоолоор “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам барих төсөл”-ийн дуусаагүй үйлдвэрлэл, бараа материал, урьдчилж төлсөн зардалд бүртгэлтэй нийт 457,253.7 сая төгрөгийн хөрөнгийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д балансаас балансад шилжүүлж, урт хугацаат хөрөнгө оруулалтаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- “Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-нд тайлант онд Засгийн газрын 175 дугаар тогтоолоор Монгол-Японы хамтарсан хуулийн этгээдэд Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын менежмент төслийг хэрэгжүүлэх хоёр дахь ээлжийн 13,116.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн, мөн “Далайн захиргаа” ТӨҮГ-т Засгийн газрын 2015 оны 180 дугаар тогтоолоор БНСУ-д бүртгэлтэй далайн тээврийн “Монгол-Саммок ложистик” хамтарсан компани байгуулан 190.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь тус тус бүртгэлтэй байна.

### 3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 556,801.6 сая, эцсийн үлдэгдэл 950,047.5 сая төгрөг болж, 393,245.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	36,799.5	36,587.9	(211.6)
Дуусаагүй үйлдвэрлэл	444,706.9	599,629.7	154,922.8
Бэлэн бүтээгдэхүүн	1,383.6	409.6	(974.0)
Бичиг хэргийн материал	51.8	155.2	103.4
Аж ахуйн материал	20,798.1	21,150.1	352.0
Сэлбэг хэрэгсэл	2,117.1	188,676.1	186,559.0
Түлш, шатах тослох материал	334.1	45,577.9	45,243.8
Барилгын засварын материал	28,368.4	47,805.6	19,437.2
Бусад хангамжийн материал	22,196.3	10,012.4	(12,183.9)
Мал амьтад	45.8	42.9	(2.9)
<b>Дүн</b>	<b>556,801.6</b>	<b>950,047.4</b>	<b>393,245.8</b>

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 393,245.9 сая төгрөгөөр өссөн нь “Монголын төмөр зам” ТӨХК нь “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төсөл”-ийн ажлын замын дээд бүтэц барих төмөр замын материал, сэлбэг хэрэгсэлд 186,622.4 сая, замын доод бүтцийн далан, гүүр, хоолойн ажил зэрэг 155,841.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий бүтээн байгуулалтын ажлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.

Оны эцэст бараа материалын нөөц үүссэн нь МТЗ ТӨХК-ийн “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төсөл”-тэй холбоотой бүтээн байгуулалтын 882,312.5 сая, иргэний нисэхийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, агаарын навигацийн үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэгийн үлдэгдэл 60,744.7 сая төгрөг бүртгэгдсэнээс шалтгаалсан байна. /МИАТ ТӨХК 41,847.1 сая, ИНЕГ 18,897.6 сая төгрөг/

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон ТӨБЗГ-ын тогтоол гараагүйгээс ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 629,003.8 сая, хөрөнгө оруулалтын дуусаагүй ажлын 746,297.9 сая төгрөгийн авто зам, зам байгууламж, гүүр зэрэг нь бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байна.

**Аудитын илрүүлэлт:**

-Худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй 621.5 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан;  
/ИНЕГ 17.3 сая, МТЗ ТӨХК 167.6 сая, АЗННС 42.0 сая, АТҮТ ТӨҮГ 209.8 сая, “Булган АЗЗА” ТӨХК 184.8 сая төгрөг/  
- МТЗ ТӨХК-д бараа материалын үлдэгдлийн дүн зөрсөн 4.0 сая, биетээр оршин байхгүй 219.9 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй;  
-Бараа материалын дансанд 690.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй;  
/МИАТ ТӨХК 658.0 сая, СХД ТХҮТ 14.0 сая, “Булган АЗЗА” ТӨХК 18.2 сая төгрөг/

**3.5.7 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,219,548.9 сая, эцсийн үлдэгдэл 5,927,642.5 сая төгрөг болж, 291,906.4 сая төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт №7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл**

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Газар	-	13,376.9	13,376.9
Биет хөрөнгө	5,441,846.8	5,180,422.6	(261,424.2)
Биет бус хөрөнгө	765,074.4	719,803.0	(45,271.4)
Бусад хөрөнгө /ТӨҮГ	12,627.7	14,040.0	1,412.3
<b>Дүн</b>	<b>6,219,548.9</b>	<b>5,927,642.5</b>	<b>(291,906.4)</b>

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө данс нь МТЗ ТӨХК төмөр замын дагуу газар эзэмших эрхийг үнэлсэн 13,376.9 сая, төрийн өмчит газруудын худалдан авсан хөрөнгө 31,576.6 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 215,132.1 сая төгрөгөөр нэмэгдэж, балансаас балансад шилжүүлж өгсөн 278,932.6 сая, акталсан 3,181.4 сая, худалдан борлуулсан 9,313.1 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансны эхний үлдэгдэл 143,915.6 сая, эцсийн үлдэгдэл 155,676.8 сая төгрөг болж, 11,761.2 сая төгрөгөөр өссөн нь ИНЕГ-ын шалгалтын нислэгийн төхөөрөмжийн 4,453.2 сая, аймаг дахь нисэх буудлуудын барилгын зураг төслийн 498.8 сая, барилгын ажлын 6,806.2 сая төгрөгийн санхүүжилтийг дуусаагүй барилга дансанд хуримтлуулан бүртгэсэнтэй холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт:**

-Баянхонгор аймаг дахь нисэх буудал хуучин ашиглаж байсан 21.1 сая төгрөгийн үнэ бүхий халаалтын тогоо биетээр байхгүй,  
-Дорнод аймаг дахь нисэх буудал барилгын дээвэрт 62.2 сая төгрөгийн их засварыг капиталжуулаагүй;  
- Улсын комисс хүлээн авсан 260,741.1 сая төгрөгийн автозам бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй;  
-МИАТ ТӨХК-д 11.3 сая, Архангай аймгийн АТТ-д 128.1 сая төгрөгийн ашигладаг элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгө, мөн 1,491.2 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын зардалд тэг өртгөөр бүртгэсэн;  
-Бараа нийлүүлэх нийт 15,805.3 сая төгрөгийн гэрээний үүргийн биелэлт хангалтгүй;  
/АТҮТ ТӨҮГ 227.1 сая, АЗННС 190.0 сая төгрөг, ИНЕГ 15,388.2 сая төгрөг/  
-“Булган АЗЗА” ТӨХК тавилга эд хогшлын зардалд 30.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэсэн байна.

**3.5.8 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 903,482.4 сая, эцсийн үлдэгдэл 1,851,676.6 сая төгрөг болж, 948,194.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>214,474.0</b>	<b>411,874.0</b>	<b>197,400.0</b>	<b>22.2</b>
Богино хугацаат зээлийн өглөг	48,707.1	52,785.3	4,078.2	2.9
Өглөг	133,393.0	343,302.2	209,909.2	18.5
Урьдчилж орсон орлого	32,373.9	15,786.5	(16,587.4)	0.8
<b>Урт хугацаат өр төлбөр дүн</b>	<b>689,008.4</b>	<b>1,439,802.6</b>	<b>750,974.2</b>	<b>77.8</b>
Урт хугацаат үнэт цаас	357,000.0	882,950.0	525,950.0	47.7
Урт хугацаат зээл	332,008.4	556,852.6	224,844.2	30.1
<b>Нийт дүн</b>	<b>903,482.4</b>	<b>1,851,676.6</b>	<b>948,194.2</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 411,874.0 сая төгрөг болж, 197,400.0 сая төгрөгөөр өссөн нь МИАТ ТӨХК-ийн нэг жилийн дотор төлөх онгоцны түрээсийн өглөг, МТЗ ТӨХК-ийн “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төсөл”-ийн чанарын баталгааг тус тус байршуулснаас шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 28,260.8 сая төгрөгийн барьцаа, 52,785.3 сая төгрөгийн богино хугацаат зээлийн, 33,164.5 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний зардлын, 20,019.8 сая төгрөгийн зээлийн хүүгийн, 2,261.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой, бусад өглөгийн дансанд байгууллагад төлөх 114,081.4 сая, татвар, НДШ-ийн 23,244.4 сая, ногдол ашгийн 7,346.6 сая, төрийн өмчит үйлдвэрийн газрын 143,013.2 сая төгрөгийн өглөгүүд тус тус бүртгэлтэй байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд МТЗ ТӨХК-ийн “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас бондын санхүүжилтийн дүнгээр үнэт цаасны өр төлбөр нэмэгдсэн, мөн БНХАУ-ын Экспорт импортын банкнаас “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн нийлүүлэх төсөл”-ийн хүрээнд зээлээр худалдан авсан тоног төхөөрөмж, АХБ-ны Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийн зээлийн санхүүжилт, МИАТ ТӨХК-ийн онгоцны түрээсийн урт хугацаат өглөгөөс тус тус шалтгаалан үүссэн өр байна.

*Аудитын илрүүлэлт:*

*-Өглөгийн дансанд 21,043.6 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй; /МТЗ ТӨХК 20,589.2 сая, Буянт-Ухаа ОУНБ 29.3 сая, ЗТХЯ-ны хөрөнгө оруулалтын 425.1 сая төгрөг/ - НӨАТ-ийн өглөг үүсгээгүй, тооцооллын зөрүүтэй 2,332.3 сая төгрөг бүртгэлтэй; /ИНҮТ 17.8 сая, МТЗ ТӨХК 2,314.5 сая төгрөг/ -Өглөгийн дансанд МТЗ ТӨХК 145.6 сая төгрөгийн сөрөг утгатай бүртгэл хөтөлсөн, МИАТ ТӨХК түрээсийн өглөг 461.1 сая төгрөгийг бүртгээгүй байна.*

**3.5.9 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,230,576.2 сая, эцсийн үлдэгдэл 7,133,370.7 сая төгрөг болж, 97,205.5 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 9. Засгийн газрын хувь оролцоо*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,251,088.7	2,244,144.8	(6,943.9)	31.5
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	40,224.3	40,714.6	490.3	0.6
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	532.9	532.9	-	-
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	2,603.3	2,005.9	(597.3)	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	850,051.1	621,991.5	(228,059.7)	8.7
Хуримтлагдсан үр дүн	1,830,473.1	1,968,030.0	137,556.9	27.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,255,489.4	2,255,837.6	348.2	31.6
Хяналтын бус хувь оролцоо	113.4	113.4	-	-
<b>Дүн</b>	<b>7,230,576.2</b>	<b>7,133,370.7</b>	<b>(97,205.5)</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 7,133,370.7 сая төгрөг болж, 97,205.5 сая төгрөгөөр буурсан нь төрийн өмчит үйлдвэрийн газрын эздийн өмчийн бусад хэсэг болон хуримтлагдсан үр дүнгээс голлон шалтгаалжээ. Үүнд:

Засгийн газрын оруулсан капитал дансны эцсийн үлдэгдэл 2,244,144.8 сая төгрөг болж, 6,943.9 сая төгрөгөөр буурсан нь улсын төсөвт 5,119.6 сая төгрөг төвлөрүүлсэн, ТӨБЗГ-ын 2021 оны 57 дугаар тогтоолын дагуу “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний төсөл”-ийн 28.5 сая ам.долларын хөрөнгийг МТЗ ТӨХК-д, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 1,600.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг шилжүүлэн бүртгэснээс шалтгаалсан байна.

Нэмж төлөгдсөн капитал дансны эцсийн үлдэгдэл 2,005.9 сая төгрөг болж, 597.3 сая төгрөгөөр буурсан нь “Налайх АЗЗА” ТӨҮГ аудитын зөвлөмжийн дагуу төрийн өмчийн дансанд үндсэн хөрөнгө шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны эцсийн үлдэгдэл 621,991.4 сая төгрөг болж, 228,059.7 сая төгрөгөөр буурсан нь төрийн өмчит компаниудын хөрөнгийн хөдөлгөөнөөс шалтгаалжээ. Тухайлбал: “Хөшгийн хөндийн нисэх буудал” ТӨҮГ нь ИНЕГ-аас оруулсан монголын талын хувь болох 3,400.0 сая төгрөгөөр эх үүсвэр өссөн, МИАТ ТӨХК 112.0 сая, ИНЕГ 462.0 сая төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэн, ГТХЗНТ 1,600.0 сая төгрөгийн эх үүсвэрийг төрийн өмчид шилжүүлснээс эх үүсвэр буурсантай холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн дансны эцсийн үлдэгдэл 1,968,030.0 сая төгрөг болж, 137,556.9 сая төгрөгөөр өссөн нь төрийн өмчит компаниудын тайлант үеийн үр дүнгийн хэлбэлзэл болон өмнөх үеийн үр дүнд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлтүүдийг бүртгэснээс голлон шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны эцсийн үлдэгдэл 2,255,837.6 сая төгрөг болж, 348.2 сая төгрөгөөр өссөн нь Улсын авто замын сангийн зарим үндсэн хөрөнгийг дахин үнэлж 384.0 сая төгрөгөөр бүртгэсэн, зарим компанийн хөрөнгийн үнэлгээг бууруулсантай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийг Улсын Их хурлын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 375,419.5 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсвийг 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн тодотголоор нийт 96,175.1 сая төгрөгөөр буюу хөрөнгө оруулалтын зардлыг 95,792.3 сая, урсгал зардлыг 382.8 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх навигацийн орлогыг 90.0 сая төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

Батлагдсан төсвийг төсвийн тодотголоор 96,175.1 сая төгрөгийг бууруулан 279,244.4 сая төгрөгөөр баталсан, мөн төсвийн гүйцэтгэлээр тайлант хугацаанд 339.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн нь төсвийн төлөвлөлтийг бодитой боловсруулаагүйг харуулж байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн тодотголоор төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх авто зам, төмөр зам, агаарын тээвэр, зам, тээврийн бодлого, удирдлага гэсэн 4 гол хөтөлбөрт

зориулан 279,244.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 12,056.9 сая төгрөгийг урсгал зардалд, 267,187.5 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд зориулахаар тусгагджээ.

Нийт зардлын 264,244.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 15,000.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 245,476.9 сая, үндсэн үйл ажиллагааны орлого 8,648.0 сая төгрөг бүрдүүлж, зарцуулсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 6,352.0 сая төгрөгөөр тасарсан нь цар тахлын улмаас орон нутаг руу явах хөдөлгөөнийг хэсэгчлэн буюу түр зогсоосон тул улсын чанартай авто замын төлбөр хураах цэгүүдийн орлого буурснаас шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 253,959.2 сая төгрөг буюу 90.9 хувьтай байгаа нь цар тахлын улмаас хөрөнгө оруулалтын зардлаас барилгын ажлын хэмжээ буурч 24,873.6 сая, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 47.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 200.8 сая төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын авто замын барилга барих, их засвар хийх төсөл, арга хэмжээнд 267,187.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 242,313.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, 13,552.8 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд, 197.9 сая төгрөгийг захиалагчийн техникийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл "Зам, тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ"-д зааснаар орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 1,728.8 сая, улсын төсөвт тээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ 171.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төвлөрүүлсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2020 оны А/167/101 дүгээр хамтарсан тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын улсын төсөвт төвлөрүүлэх 2020 оны навигацыйн орлогын төлөвлөгөөг 75,000.0 сая төгрөгөөр батлагдсаныг бүрэн төвлөрүүлсэн.

Мөн ТӨБЗГ-ын 2020 оны 315 дугаар тогтоолоор Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад 7,981.8 сая төгрөгийн ногдол ашиг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсаныг 103.3 хувийн гүйцэтгэлтэй төвлөрүүлсэн байна.

#### Хүснэгт 10. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Зөрүү	Хувь
Улсын тэмдэгтийн хураамж /ЗТХЯ, АТҮТ ТӨҮГ/	-	1,728.8	1,728.8	-
Гэрчилгээний үнэ /ЗТХЯ/	-	171.1	171.1	-
Навигацыйн орлого /ИНЕГ/	75,000.0	75,000.0	-	100.0
Ногдол ашиг /ТӨҮГ, ТӨХК/	7,981.8	8,248.8	267.0	103.3
Монгол Улсын Төрийн далбаа мандуулж ашигласны орлого /"Далайн захиргаа" УТҮГ/	223.0	223.0	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>82,981.8</b>	<b>85,328.7</b>	<b>2,346.9</b>	<b>101.1</b>

Ногдол ашгийн орлого давсан нь ЗТХТ ТӨҮГ 2020 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас төлөх ногдол ашгийг урьдчилан тооцоолж 45,000.0 сая төгрөг илүү, мөн МТЗ ТӨХК 222.0 сая төгрөгийн илүү буюу ТӨБЗГ-ын актын төлбөрийг нэмж төлсөнтэй холбоотой байна.

## Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Хөрөнгө гаргах тухай” 150 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн БНХАУ-д айлчлал хийхэд үүссэн онцгой үүргийн нислэгийн зардал 97.8 сая, Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний байгууллагын санхүүжилтээр “Жолооч танд” төслийн эхний шатны санхүүжилт 4.0 сая, нийт 101.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Улсын авто замын сангийн давсан орлогын зарцуулагдаагүй үлдэгдлээс тайлант онд ЗТХТ ТӨҮГ-ын 2018 оны 2018/007 дугаар гэрээт ажил авто замын тэмдэг, тэмдэглэгээний зардалд 23.6 сая төгрөгийг зарцуулж, 226.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн тухай хуульд заагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн гүйцэтгэлийн зарим үр дүн улс оронд үүссэн нөхцөл байдлын улмаас төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна. Тухайлбал:

- Зам, тээврийн салбарын гол үзүүлэлт болох ачаа болон зорчигчийн эргэлтийн үзүүлэлтийг авч үзвэл агаарын тээврийн салбарт ачаа тээвэрлэлтийн төлөвлөгөө 51.0 хувийн биелэлттэй байсан бол зорчигч тээвэрлэлтийн төлөвлөгөөг 37.0 хувиар биелүүлсэн.
- Улсын чанартай авто замын хэмжээг 480 км уртасгах төлөвлөгөө 28.0 хувиар тасарч 344 км авто замыг ашиглалтад оруулсан байна. Харин ашиглалтад оруулах гүүрний хэмжээг 298.9 метрээр давуулан биелүүлсэн буюу 648.9 метр гүүр барьсан.
- Төмөр замын салбарт томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг хийж эхэлсэн бөгөөд Тавантолгой-Зүүнбаян чиглэлд 80 км төмөр зам барихаас 62.4 км авто замын барилгын ажлыг гүйцэтгэж, төлөвлөгөөг 78.0 хувиар биелүүлсэн бөгөөд энэ чиглэлд 230 км сараалж зам буюу төмөр замын суурь болон үндсэн бүтцийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Дэлхий нийтээр тархсан коронавирус (Covid-19) цар тахлын халдварт өвчний улмаас Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын холбогдох шийдвэрээр олон улсын хуваарьт бүх нислэг, авто замыг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн үе шаттайгаар, 3 дугаар сараас эхлэн бүрэн зогсоосон нь Зам, тээврийн салбарын хэмжээнд өмнөх онтой харьцуулахад орлого 524,663.3 сая төгрөг буюу 41.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал:

- ИНЕГ-т Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр өнгөрөлтийн нислэг үйлддэг гадаадын агаарын тээвэрлэгчдийн нислэгийн тоо 62,221-ээр буурснаар навигацийн орлого 51,999.3 сая төгрөгөөр буюу 20.6 хувиар, туслах үйл ажиллагааны орлого 14,355.3 сая төгрөгөөр буюу 68.7 хувиар тасарсан, улсын төсөвт төвлөрүүлэх навигацийн орлогыг 50.0 хувиар буюу 75,000.0 сая төгрөгөөр бууруулан баталсан;



- МИАТ ТӨҮГ-т нислэг үйлдвэрлэл буюу агаарын хөлгөөр 215.5 мянган зорчигч, 6,391.9 тонн ачаа тээвэрлэснээр орлогын төлөвлөгөө 326,900.0 сая төгрөгөөр буюу 63.9 хувиар тасарсан;
- АТҮТ ТӨҮГ-ын авто замын зорчигч болон ачаа тээвэрлэлтийг түр зогсоосноор 4,035.5 сая төгрөгөөр буюу 34.5 хувиар, техникийн бүртгэлийн орлого 422.8 сая төгрөгөөр буюу 13.6 хувиар тус тус орлого огцом буурч, төлөвлөгөө тасарсан байна.

Дээрх хүчин зүйлсээс шалтгаалан үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого эрс буурснаар төрийн өмчит 7 үйлдвэрийн газрын 2020 оны санхүүгийн тайлан 66,542.4 сая төгрөгийн алдагдалтай гарсан байна.

### 3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд 10851 мэдээлэл байршуулахаас хугацаанд нь 9798, хугацаа хоцроож 1053 мэдээллийг тус тус байршуулсан байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 1,194.3 сая төгрөгийн зөрчилд 21 акт тогтоосноос 1,168.7 сая төгрөгийн 15 төлбөрийн актыг барагдуулсан, 25.6 сая төгрөгийг дутуу, 6,754.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 38 албан шаардлага хүргүүлснээс 5,241.6 сая төгрөгийн 31 албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Нийт 145 зөвлөмж өгснөөс 120 зөвлөмжийг хэрэгжүүлж, 20 зөвлөмж хэрэгжих шатандаа, огт хэрэгжүүлээгүй 5 буюу зөвлөмжийн хэрэгжилт 81.9 хувьтай байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	21	1,194.3	15	1,168.7	91.4
Албан шаардлага	38	6,754.7	31	5,241.6	77.6
Зөвлөмж	145	19,632.6	120	16,079.1	81.9
<b>Нийт дүн</b>	<b>204</b>	<b>27,581.6</b>	<b>166</b>	<b>22,489.4</b>	<b>83.6</b>

### 3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад дараах анхаарал татахуйц, дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай асуудлууд байна. Үүнд:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрыг 2005 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Төрийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэж 000125468 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр тогтоолоор тус газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд төрийн захиргааны байгууллага гэж тодорхойлсон боловч Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолыг мөрдөж ажилладаггүй, байгууллагын статус, эрх зүйн орчин тодорхой бус

байгаагаас шалтгаалан агентлагийн бүтэц, зохион байгуулалт, албан хаагчдын цалингийн шатлал, ангилал, шагнал урамшуулал нь бусад хууль тогтоомжтой нийцээгүй;

2. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны “Төсвийн төвлөрүүлэн захирагчдын жагсаалт батлах тухай” 207 дугаар тогтоолд ИНЕГ-ыг хамруулаагүй нь санхүүгийн нэгтгэсэн тайланд ойлголтын зөрүү үүсгэж, аудитын явцад дараах хүндрэл учруулж байна:

- ИНЕГ нь улсын төсвөөс олгосон санхүүжилтэд УСНББОУС-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэдэггүй;
- ИНЕГ-ын даргын 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/443 дугаар тушаалаар ИНҮТ-ийн бүтцэд багтсан “Буянт-Ухаа” ОУНБ, Сэргээн засах амралт, 13 аймаг дахь орон нутгийн нисэх буудлууд нь тусдаа бие даасан санхүүгийн тайлан гаргаж, ижил хугацаанд аудитад хамрагдан ИНҮТ-д нэгтгүүлж, төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгүүлэн, нэгтгэсэн санхүүгийн тайланг 3 дугаар сарын 15-ны өдөр буюу аудит хийж дуусах хугацаанд эцэслэн гаргаж, ИНЕГ-ын санхүүгийн тайланд нэгтгэдэг;
- Буянт-Ухаа ОУНБ, Сэргээн засах амралт нь ИНҮТ-тэй ижил хугацаанд санхүүгийн тайланд аудит хийлгэхээр зохицуулсан нь нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахад цаг хугацааны хувьд давхацсан;
- ИНҮТ-ийн бүтцэд ордог Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба, Агаарын навигацийн үйлчилгээний газар бие даасан тусдаа санхүүгийн тайлан гаргаж тайлагнадаг байна.

3. Зам, тээврийн яамны /хуучнаар/ Худалдаа хөгжлийн банкин дахь улсын тэмдэгтийн хураамжийн орлого төвлөрүүлэх 2600074943 тоот “Тэг үлдэгдэлтэй данс”-ыг Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2013 оны 24/24/А-9 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, банканд нээх, хаах журам”-ын дагуу гурвалсан гэрээ байгуулаагүй, арилжааны банкны үлдэгдлийг тайлант хугацаанд тухай бүр төвлөрүүлэлгүй 2 жил дамжуулсан;

4. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалаар баталсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирлын 2020 оны А/287 дугаар тушаалаар баталсан “Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг дуудлага худалдаагаар зохион байгуулах удирдамж”-ийн дагуу 2021 оны хоёрдугаар дугаар сард дуудлага худалдааг зохион байгуулан тус журмын 12.9-д зааснаар үнэ хаялцуулах ажиллагаагаар төвлөрүүлсэн орлогыг тусгай санд төвлөрүүлэх байтал 194 ширхэг дугаарын дуудлага худалдааны дэнчин болон ялагч нарын орлогыг АТҮТ ТӨҮГ-ын үндсэн үйл ажиллагааны Хаан банкны 5039831355 тоот дансанд 560.5 сая, Голомт банкны 1605186115 тоот дансанд 40.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн;

5. МТЗ ТӨХК-ийн хэрэгжүүлж буй Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих бүтээн байгуулалтын дэд ажлын хэсэг төслийн ажлын гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулахдаа компанийн санхүү, төсвийн эх үүсвэр, төлбөрийн чадавхтай уялдуулж зохион байгуулаагүйгээс бүрэн гүйцэтгэгдсэн гүүр, хоолойн ажлын санхүүжилт 50.3 хувь, доод бүтцийн ажлын санхүүжилт 22.0 хувь, зураг төслийн ажлын санхүүжилт 12.0 хувиар тус тус тасарч, гэрээт ажлын гүйцэтгэлтэй холбоотой өндөр дүнтэй өр төлбөр үүссэн;

Төслийн ажилд туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулах, түүнд хяналт тавих талаар журамд тусгаагүйгээс ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээний үндсэн дээр ажил гүйцэтгэж буй туслан гүйцэтгэгчид, гэрээт ажлыг цааш гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж, захиалагчийн зүгээс хянах боломжгүй төсөл дагасан компаниас компанийн хооронд өрийн сүлжээ үүсэх нөхцөл бүрдсэн. Мөн төслийн ажлын туслан гүйцэтгэгчдийн тоо төлөвлөснөөс нэмэгдэж талбайн ажлын хяналтын зардал хэтрэх үндэслэл болсон зэрэг нь анхаарал татахуйц асуудал байлаа.

6. Авлигатай тэмцэх газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн “Иргэний нисэхийн ерөнхий газарт ажиллах ажлын удирдамж”-аар 2019, 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлд хяналт шалгалт хийгдэж дуусаагүй байснаас шалтгаалан ИНЕГ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөрөнгө оруулалтын ажил аудитад хамрагдаагүйг гүйцэтгэлийн аудитад хамруулах, мөн өглөгийн данс, урьдчилж орсон орлогын бүртгэл, хүлээн зөвшөөрөлтөд нарийвчилсан горим сорил гүйцэтгэх;

7. МИАТ ТӨХК-ийн цалингийн нэмэгдлүүд болон гадаадын 6 төлөөлөгчийн газруудын батлагдсан төсөв, түүний бодит гүйцэтгэл, хяналтын үйл явц, насжилт өндөртэй гаднын харилцагчийн авлага барагдуулалт, зардлын ангиллын хуваарилалт, гадаадын тийз борлуулалтын агентлагийн гэрээний үүргийн биелэлт түүний хэрэгжилтэд нарийвчилсан горим сорил гүйцэтгэх;

8. Тайлант оны эцсийн байдлаар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих 1,584,679.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын нийт гүйцэтгэл 74.9 хувь, гүйцэтгэгчид олгосон санхүүжилт 60.0 хувь, батлагдсан төсвийг 229,433.2 сая төгрөгөөр хэмнэсэн. Төслийн ажлын санхүүжилтийн эх үүсвэрийн дутагдлыг 2021 онд шийдвэрлэж, гүйцэтгэлийг бүрэн хангахаар зорьж ажиллаж байна. МТЗ ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитын хамрах хүрээнээс үүдэж дээрх бүтээн байгуулалтын ажлын үр дүн, үр нөлөөг тооцож дүгнээгүй тул төслийн хөрөнгө оруулалтын үр дүнг гүйцэтгэлийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 53 тайланг нэгтгэснээс аудитад 46 тайлан бүрэн хамрагдаж “Зөрчилгүй” 41, “Хязгаарлалттай” 4 санал дүгнэлт өгсөн бөгөөд “Итгэл үзүүлсэн” 1, аудитын түүвэрт 7 тайлан хамрагдсан байна.

##### 4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 415,336.1 сая төгрөгийн 51 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй нийт 36,968.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,592.6 сая төгрөгийн зөрчилд 19 төлбөрийн акт тогтоож, 27,932.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 64 албан шаардлага хүргүүлж, 6,443.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 122 зөвлөмж өгсөн байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Иргэний нисэхийн ерөнхий газар, “Монголын төмөр зам” ТӨХК, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Булган АЗЗА” ТӨХК-ууд “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байна.

##### 4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 39,577.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 120.5 сая төгрөгийн алдааг залруулж, 11.5 сая төгрөгийн 1 зөрчилд акт тогтоож, 2,477.0 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 36,968.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

##### Залруулсан алдаа

ЗТХТ ТӨҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд ТӨБЗГ-аас 2021 онд улсын төсөвт ногдол ашиг төвлөрүүлэх тогтоол батлагдаагүй байхад 120.5 сая төгрөгийн өглөг үүсгэж, 45.0 сая төгрөгийн илүү төлөлттэй тайлагнасныг залруулга хийсэн.

##### Төлбөрийн акт

“Автоимпекс” ХК нь 2020 оны санхүүгийн тайланд бүртгэлтэй ногдол ашгийн өглөг 11.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д “Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.5.1-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1-д зааснаас бусад төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг” гэж заасныг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

##### Албан шаардлага:

1. Шилэн дансны цахим хуудсанд нийт 10851 мэдээлэл байршуулахаас 1053 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, мөн цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 227,265.5 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээний шийдвэрийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т “төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн

хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. Иргэний нисэхийн ерөнхий газарт Үндэсний аудитын газраас 2018, 2019 онд өгсөн гадаадын болон дотоодын авиа компаниудаас авах хугацаа хэтэрсэн, тооцоо нийлсэн актгүй нийт 2,477.0 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа талаарх албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т *"өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3. МИАТ ТӨХК нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Шинэ коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 30 дугаар тогтоолын 9 дүгээр хэсэгт заасан "БНХАУ-ын Ухань хотод сурч байгаа Монгол иргэдээ татан авах тухай" заалтын дагуу 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр УБ-Ухань-УБ чиглэлд онцгой үүргийн нислэг гүйцэтгэхэд 57,950 ам доллар буюу 165.1 сая төгрөгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6-д *"Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, компанийн гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"*, 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТЕЗ болон УОК-т албан шаардлага хүргүүлсэн

4. МИАТ ТӨХК-ийн санхүүгийн тайланд Зам, тээврийн хөгжлийн яамны ажилтнууд болон нэр бүхий албан тушаалтнуудын онгоцны билетийн үлдэгдэл 14.2 сая, мөн Батлан хамгаалах яамны "Газрын үйлчилгээ"-ний 230.0 сая төгрөг, нийт 244.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага он дамжин бүртгэгдсээр байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6-д *"Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, компанийн гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"*, 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТЕЗ болон БХЯ-нд албан шаардлага хүргүүлсэн

5. МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын Б/645 дугаар тушаалаар ажлаас үндэслэлгүй халагдсан нэр бүхий ажилтанд шүүхийн шийдвэрээр ажилгүй байх хугацааны нөхөн олговор 34.5 сая төгрөг олгохоос 20.0 сая төгрөгийг байгууллагаас олгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д *"Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ"* гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын *"эрх ба үүрэг"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: ЗТХЯ-ны ХШҮДАГ-т албан шаардлага хүргүүлсэн

### **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

#### **1. Дотоод хяналттай холбоотой асуудал**

- 1.1. Илрүүлэлт: Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар залруулагдаагүй нийт 36,968.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,592.6 сая төгрөгийн 19 акт тогтоож, 27,932.3 сая төгрөгийн 64 албан шаардлага хүргүүлж, 6,443.6 сая төгрөгийн 122 зөвлөмж өгсөн нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-д *"төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах"*, 14 дүгээр зүйлийн 14.2.10-т *"өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 19 дүгээр зүйлийн 19.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно"* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын *"эрх ба үүрэг"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа зөрчилд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлд суурилсан төлөвлөгөө боловсруулж, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нягтлан бодогч нарын ажлын үр дүнг үнэлж, хариуцлагажуулан, ажлын уялдааг хангаж ажиллах.

#### **5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд аудит хийх хугацаанд түүвэрт хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчил**

5.1. ЗТХЯ-ны хөрөнгө оруулалтын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 849.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 195.5 сая төгрөгийн 1 зөрчилд акт тогтоож, 654.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

##### **Төлбөрийн акт:**

1. Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд 2013 онд автозамын материалын үнийн өсөлтийн зөрүү олгосноос хэмнэгдсэн 195.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д *"Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдээгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдээгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ"*, 45.2.2-д *"төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдээгдэл"* гэж заасныг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлагналын *"үнэн зөв байдал"*, *"эрх ба үүрэг"* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

## **Зөвлөмж:**

### **1. Авлагын данстай холбоотой асуудал**

- 1.1. Илрүүлэлт: Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн авлага дансанд 2006-2008 онд үүссэн хугацаа хэтэрсэн олон жилийн насжилттай, тооцоо нийлсэн актгүй 229.3 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн, он дамжсан авлагыг барагдуулах арга хэмжээ авч зохион байгуулж ажиллах.

### **2. Өглөгийн данстай холбоотой асуудал**

- 2.1. Илрүүлэлт: Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд авто зам, замын байгууламжийн 2012-2016 онд үүссэн чанарын баталгаат хугацаа дууссан нийт 4,823.7 сая төгрөгийн барьцаа хөрөнгийн өглөг бүртгэгдсэнээс тооцоо нийлсэн актгүй 425.1 сая, шүүхийн маргаантай 2,958.5 сая төгрөгийн хөрөнгө байршиж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Авто замын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т "Шинээр барьж байгуулсан авто зам, замын байгууламжийн чанарын баталгаат хугацаа нь гүйцэтгэгч болон техник, технологийн хяналт тавьсан хуулийн этгээдэд тус бүр гурван жил байна" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 2.2. Өгсөн зөвлөмж: Хөрөнгө оруулалтын ажлын чанарын баталгаат хугацаа дууссан барьцаа хөрөнгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, гэрээт ажлын үр дүнг тооцох.

### **3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

- 3.1. Илрүүлэлт: Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд Улсын комисс хүлээн авч, ашиглалтад орсон Баянхонгор-Байдраг чиглэлийн 129.4 км, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114.0 км улсын чанартай автозам бусад эргэлтийн хөрөнгө дансанд 260,741.1 сая төгрөгөөр бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.9-д "хөрөнгө оруулалтын арга хэмжээ хэрэгжиж дууссаны дараа хөрөнгө оруулалтын үр дүнгийн талаарх тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх", Авто замын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10-т "олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах, бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, үндсэн хөрөнгийн бүртгэлд оруулах, элэгдэл хорогдлыг тооцох, бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 3.2. Өгсөн зөвлөмж: Улсын комисс хүлээн авсан, ашиглалтад орсон авто зам, замын байгууламжийг ашиглагч байгууллагад шилжүүлэх.

5.2. Автозамын норм нормативын сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 363.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 81.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 232.0 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 50.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

## **Албан шаардлага:**

1. Тайлант оны эцэст 6 аж ахуйн нэгж байгууллагатай нийт 190.0 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан боловч дурдсан хугацаанд ажлыг хүлээлгэж өгөөгүй, гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д *“Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”*, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 142 дүгээр тушаалаар баталсан *“Автозамын норм нормативын сангийн ажиллах журам”-ын 2.8.2-т “Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийг боловсруулах дарааллыг тогтоох санал оруулах, сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх”* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын *“эрх ба үүрэг”*, *“иж бүрэн байх”* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. Стандарт, норм нормативыг хэвлэн олшруулахад 26.0 сая, шторк хийлгэхэд 16.0 сая, нийт 42.0 сая төгрөгийн ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д *“Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үндэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”*, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т *“Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”*, 34 дүгээр зүйлийн 34.1-д *“Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараах нөхцөлд хэрэглэж болно”* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын *“эрх ба үүрэг”*, *“иж бүрэн байх”* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

### **Зөвлөмж:**

#### **1.Өглөгийн данстай холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: АЗННС урьд онд байгуулсан гэрээний үлдэгдэл 50.0 сая төгрөгийг өглөгөөр бүртгэлгүй, тайлант хугацааны зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т *“Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”*, 14.4.3-т *“бүх өр төлбөр”*, 18 дугаар зүйлийн 18.1-д *“Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын *“эрх ба үүрэг”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Тайлант хугацааны эцэст өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтлөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Харьяа байгууллагууд	Дүгнэлтийн хэлбэр				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Итгэл үзүүлсэн	Түүвэрт хамруулсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Төсвийн ерөнхийлөн захирагч</b>											
1	Зам, тээврийн хөгжлийн сайд		1			1	11.5	2	2,477.0	-	-
	<b>ДҮН</b>		<b>1</b>			<b>1</b>	<b>11.5</b>	<b>2</b>	<b>2,477.0</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Төсвийн төвлөрүүлэн захирагч</b>											
1	Иргэний нисэхийн ерөнхий газар	15	1	1	3	2	50.6	16	1,214.8	13	109.9
	<b>ДҮН</b>	<b>15</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>50.6</b>	<b>16</b>	<b>1,214.8</b>	<b>13</b>	<b>109.9</b>
<b>Засгийн газрын тусгай сан</b>											
1	Улсын автозамын сан	1				1	0.2	1	-	3	6.7
2	Автозамын норм нормативын сан				1	-	-	2	232.0	1	50.0
	<b>ДҮН</b>	<b>1</b>			<b>1</b>	<b>1</b>	<b>0.2</b>	<b>3</b>	<b>232.0</b>	<b>4</b>	<b>56.7</b>
<b>Төсөл хөтөлбөр</b>											
1	Улиастай-тосон 67км төсөл				1	-	-	-	-	-	-
	<b>ДҮН</b>				<b>1</b>						
<b>Төрийн өмчит үйлдвэрийн газар</b>											
1	"Монголын төмөр зам" ТӨХК		1			2	681.2	3	23,168.5	5	3,039.6
2	МИАТ ТӨХК	1				-	-	8	1,968.7	10	1,338.6
3	Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ		1			-	-	9	511.1	27	603.3
4	Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	1				-	-	2	11.7	4	14.4
5	Хөшгийн хөндий нисэх онгоцны буудал ТӨХК	1				-	-	1	-	1	-
6	Далайн захиргаа УТҮГ	1				1	0.7	1	-	3	12.0
7	"Дархан АЗЗА" ТӨХК	1				1	0.8	-	-	4	4.8
8	"Дорноговь АЗЗА" ТӨХК	1				-	-	-	-	6	16.7
9	"Багануур АЗЗА" ТӨХК	1				1	0.1	1	-	3	17.2
10	"Увс аймгийн АЗЗА" ТӨХК	1				-	-	-	-	-	-
11	"Говь-Алтай АЗЗА" ТӨХК	1				-	-	-	-	-	-
12	"Ховд аймгийн АЗЗА" ТӨХК	1				-	-	-	-	-	-
13	"Баянчандмана АЗЗА" ТӨХК	1				-	-	-	-	1	-
14	"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК	1				-	-	3	15.0	2	0.9
15	"Завхан АЗЗА" ТӨХК	1				-	-	-	-	2	208.0
16	"Орхон АЗЗА" ТӨХК	1				-	-	3	13.5	3	10.7
17	"Эрдэнэсант АЗЗА" ТӨХК	1				-	-	-	-	3	172.3
18	"Төв АЗЗА" ТӨХК	1				1	3.8	-	-	5	15.8
19	"Өвөрхангай АЗЗА" ТӨХК	1				-	-	1	-	2	10.2
20	"Налайх АЗЗА" ТӨХК	1				-	-	1	-	2	27.2
21	"Харгуй" ТӨХК	1				-	-	-	-	2	84.1
22	"Талын зам" ТӨХК	1				-	-	-	-	1	-
23	"Хөвсгөл АЗЗА" ТӨХК	1				-	-	-	-	1	-
24	"Хархорин АЗЗА" ТӨХК	1				-	-	1	-	1	-
25	"Булган АЗЗА" ТӨХК		1			6	7.8	8	607.4	4	17.0
26	"Архангай АЗЗА" ТӨХК	1				-	-	-	-	2	6.6
27	"Автоимпекс" ТӨХК				1	-	-	-	-	-	-
	<b>ДҮН</b>	<b>23</b>	<b>3</b>			<b>12</b>	<b>694.3</b>	<b>42</b>	<b>26,295.8</b>	<b>94</b>	<b>5,599.4</b>
<b>Төсвийн шууд захирагч</b>											
1	Зам, тээврийн хөгжлийн яам	1				2	1,651.4	2	189.7	5	18.3
2	"Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах төв" УТҮГ	1				1	0.6	-	-	3	4.9
3	Хөрөнгө оруулалт, урсгал засвар				1	1	195.5	1	-	3	654.4
	<b>ДҮН</b>	<b>2</b>			<b>1</b>	<b>4</b>	<b>1,847.5</b>	<b>3</b>	<b>189.7</b>	<b>11</b>	<b>677.6</b>
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>41</b>	<b>5</b>	<b>1</b>	<b>7</b>	<b>20</b>	<b>2,604.1</b>	<b>66</b>	<b>30,409.3</b>	<b>122</b>	<b>6,443.6</b>

**7. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт**

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая төгрөг/	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
<b>ТӨЛБӨРИЙН АКТ</b>					
<b>Төсвийн ерөнхийлөн захирагч</b>					
1	<b>Зам, тээврийн хөгжлийн сайдын багц:</b> “Автоимпекс” ХК нь 2020 оны санхүүгийн тайланд бүртгэлтэй ногдол ашгийн өглөг 11.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	11.5	Төлбөрийн акт тогтоох	“Автоимпекс” ХК-ийн захирал	С.Отгонбаатар
2	<b>ЗТХЯ-ны Хөрөнгө оруулалт:</b> Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд 2013 онд автозамын материалын үнийн өсөлтийн зөрүү олгосноос хэмнэгдсэн 195.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй.	195.5	Төлбөрийн акт тогтоох	ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	С.Батболд Г.Алтангэрэл
<b>Төсвийн төвлөрүүлэн захирагч</b>					
3	<b>Иргэний нисэхийн ерөнхий газар:</b> Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл 44.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	44.5	Төлбөрийн акт тогтоох	ИНЕГ-ын дарга СХОГ-ын дарга	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн
4	<b>ИНУТ-д</b> 2017 оноос өмнө үүссэн нэр бүхий ажилтнуудын төлөх өрийг төлүүлж барагдуулах ажлыг зохион байгуулаагүй байна.	6.1	Төлбөрийн акт тогтоох	ИНУТ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч	П.Мөнхжаргал С.Отгонбаяр
<b>Засгийн газрын тусгай сан</b>					
5	<b>Улсын автозамын сан:</b> Зарим нэр бүхий ажилтнуудад ажилласан хоног дутуу байхад хоол, унааны зардалд бүтэн ажилласнаар тооцож илүү мөнгө олгосон.	0.2	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	Р.Буд Ц.Мөнхтуяа
<b>Төрийн өмчит үйлдвэрийн газар</b>					
6	<b>МТЗ ТӨХК:</b> Ашиглалт багатай 14 харилцах дансны үлдэгдэл 437.5 сая төгрөг байгаагийн 371.2 сая төгрөг нь Хөгжлийн банкны 2015 оноос хойш ашиглаагүй 2 харилцах дансны үлдэгдэл байна.	371.2	Төлбөрийн акт тогтоох	МТЗ ТӨХК-ний гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Р.Батсүх Д.Даваадорж
7	<b>МТЗ ТӨХК:</b> Тайлант оны орлогыг гэрээний дүнтэй тулган шалгахад Ложистикийн төвийн түрээсийн орлогыг 310.0 сая төгрөгөөр дутуу тооцож бүртгэсэн.	310.0	Төлбөрийн акт тогтоох	МТЗ ТӨХК-ний гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Р.Батсүх Д.Даваадорж
8	<b>“Далайн захиргаа” УТҮГ:</b> ТӨБЗГ-ын тогтоолоор нээлттэй дуудлага худалдаагаар худалдсан нэг ширхэг автомашины бэлэн мөнгөний орлогын зөрүүг мөнгөн хөрөнгийн тайланд тусгаагүй.	0.7	Төлбөрийн акт тогтоох	Дарга нягтлан бодогч	С.Түвшинтөр П.Мөнхбат
9	<b>“Дархан АЗЗА” ТӨХК:</b> Цалин ээлжийн амралт давхардсан нэмэгдэл хөлс илүү олгосон.	0.8	Төлбөрийн акт тогтоох	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Баясгалан Г. Сэлэнгэ
10	<b>“Төв АЗЗА” ТӨХК:</b> Эдийн засагчийн ажлыг хавсран гүйцэтгүүлсэн.	3.8	Төлбөрийн акт тогтоох	Гүйцэтгэх захирал	Д.Болдбаатар
11	<b>“Багануур АЗЗА” ТӨХК:</b> Албан томилолтын үнэмлэхийг санхүүгийн тэмдгээр баталгаажуулсан.	0.08	Төлбөрийн акт тогтоох	Захирал Ерөнхий нягтлан	А.Алтангадас А.Сарантуяа
12	<b>“Булган АЗЗА” ТӨХК:</b> Тооллогоор 0.86 сая төгрөгийн үндсэн хөрөнгө дутаасан.	0.86	Төлбөрийн акт тогтоох		

13	<b>“Булган АЗЗА” ТӨХК:</b> Тооллогоор 1.98 сая төгрөгийн бараа материал дутаасан.	1.98	Төлбөрийн акт тогтоох	Захирал	Э.Пүрэвдэмбэрэл
14	<b>“Булган АЗЗА” ТӨХК:</b> Тогтоол зөрчин зарцуулсан гар утасны төлбөр-150.0 мянга, шинэ жилийн баяр ёслолын арга хэмжээ-1,924.0 мянган төгрөг зарцуулсан байна.	2.1	Төлбөрийн акт тогтоох	Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч	Г.Цэцэгмаа Д.Бурмаа
15	<b>“Булган АЗЗА” ТӨХК:</b> Зээлийн хүү илүү тооцон олгосон.	0.06	Төлбөрийн акт тогтоох		
16	<b>“Булган АЗЗА” ТӨХК:</b> Илүү тооцон олгосон цалингийн урамшуулал олгосон.	1.99	Төлбөрийн акт тогтоох		
17	<b>“Булган АЗЗА” ТӨХК:</b> Няравын хувийн дансаар гүйлгээ хийж бүртгэл тайланд тусгаагүй.	0.85	Төлбөрийн акт тогтоох		
<b>Төсвийн шууд захирагч</b>					
18	<b>ЗТХЯ:</b> Улсын комисст хүлээлгэж өгсөн Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км, Цахир-Тосонцэнгэлийн чиглэлийн 127.1 км, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км, Баянхонгор-Байдрагийн чиглэлийн 129.4 км авто замын техникийн хяналтын зардлаас хэмнэгдсэн 345.9 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй.	345.9	Төлбөрийн акт тогтоох	ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч Нягтлан бодогч	С.Батболд Г.Алтангэрэл О.Очгэрэл
19	<b>ЗТХЯ:</b> Улсын тэмдэгтийн хураамжийн Худалдаа хөгжлийн банкин дахь 2600074943 дугаар улсын тэмдэгтийн хураамж төвлөрүүлдэг “Тэг үлдэгдэлтэй” дансны 2019, 2020 оны үлдэгдэл нийт 1,305.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй.	1,305.5	Төлбөрийн акт тогтоох	ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч Нягтлан бодогч	С.Батболд Г.Алтангэрэл О.Очгэрэл
20	<b>ГТХЗНТөв:</b> Гэрээт ажилтанд урамшуулал олгосон.	0.6	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	А.Буяннэмэх С.Золзаяа
<b>Төлбөрийн актын нийт дүн</b>		<b>2,604.1</b>			
<b>АЛБАН ШААРДЛАГА</b>					
<b>Зам, тээврийн хөгжлийн сайд</b>					
1	ИНЕГ-т Үндэсний аудитын газраас 2018, 2019 онд өгсөн гадаадын болон дотоодын авиа компаниудаас авах хугацаа хэтэрсэн, тооцоо нийлсэн актгүй нийт 2,477.0 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа талаарх албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.	2,477.0	Албан шаардлага хүргүүлэх	Зам, тээврийн хөгжлийн яам ИНЕГ	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
2	Шилэн дансны цахим хуудсанд нийт 10851 байршуулахаас 1053 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, мөн цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 227,265.5 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээний шийдвэрийг байршуулаагүй байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	С.Батболд Г.Алтангэрэл
<b>Төсвийн төвлөрүүлэн захирагч</b>					
3	<b>ИНЕГ:</b> Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 183/ШШ2019/0036 дугаар шийдвэрээр нийт 82.2 сая төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий хоёр ажилтанд олгосон.	82.2	ТЕЗ-д албан шаардлага хүргүүлэх	Зам, тээврийн хөгжлийн яам ИНЕГ-ын дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	ХШУДАГ Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Н.Наранцэцэг
4	<b>ИНЕГ:</b> Гадаад сургалтын 2013-2020 онд үүссэн 3 суралцагчийн 107.1 сая төгрөгийн авлагыг барагдуулж ажиллаагүй.	107.1	Албан шаардлага хүргүүлэх	ИНЕГ-ын дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Н.Наранцэцэг

5	<b>ИНЕГ:</b> Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан орон нутагт эрх шилжүүлсэн 17.3 сая төгрөгийн уурын зуухны холболтын ажлыг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд гэрээ байгуулан ажилласан.	17.3	Албан шаардлага хүргүүлэх	ИНЕГ-ын дарга СХОГ-ын дарга ХАА-ны менежер	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Ч.Болдбаатар
6	<b>ИНЕГ:</b> Иргэний нисэхийн чиглэлээр суралцуулах журмын 4.2 дахь заалтыг нягтлан бодогчоор Канад улсад 121.9 сая төгрөгөөр суралцуулсан, мөн гадаадад суралцуулах гэрээгээр 2015 онд 2 хүнд 506.4 сая, 2016 онд 2 хүнд 215.9 сая төгрөгийг зарцуулсан боловч одоог хүртэл сургуулиа төгсөөгүй, сургалтын гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй байна.	844.2	Албан шаардлага хүргүүлэх	ИНЕГ-ын дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Н.Наранцэцэг
7	<b>ИНЕГ:</b> Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга угсралтын ажилд 2011-2019 онд "Үүрэг трейд" ХХК-нд нийт 15,388.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч 2019 оны 10 дугаар сард Техникийн болон Улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтад оруулах ажил хийгдээгүй, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	ИНЕГ-ын дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Н.Наранцэцэг
8	<b>ИНЕГ:</b> Гадаадын авиа компаниудаас 5,282.6 сая, дотоодын авиа компаниудаас авах 1,829.2 сая төгрөгийн навигацийн төлбөрийн авлага барагдуулах ажил удаашралтай байна. Тухайлбал: Гадаадын дампуурсан авиа компаниас авах 1998-2017 онд үүссэн хугацаа хэтэрсэн 2,408.6 сая, дотоодын авиа компаниудаас авах 2006-2019 онд үүссэн хугацаа хэтэрсэн 68.5 сая төгрөгийн тус тус авлагыг барагдуулж ажиллаагүй талаар 2018, 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	ТЕЗ-д албан шаардлага хүргүүлэх	ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	С.Батболд Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Н.Наранцэцэг
9	<b>ИНУТ:</b> Тайлант онд шүүхийн тогтоолоор нийт 31.4 сая төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий хоёр ажилтанд олгосон боловч тус байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлээгүй байна.	31.4	Албан шаардлага хүргүүлэх	ИНУТ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч	П.Мөнхжаргал С.Отгонбаяр
10	Шилэн дансны цахим хуудсанд <b>ИНУТ</b> 16 мэдээлэл, Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба 3 мэдээллийг тус тус хугацаа хоцроон байршуулсан байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	ИНУТ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч	П.Мөнхжаргал С.Отгонбаяр
11	ИНЕГ-ын харьяа <b>Сэргээн засах амралтын газар</b> хугацаа хэтэрсэн өндөр насжилттай 9.7 сая төгрөгийн авлагад тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	9.7	Албан шаардлага хүргүүлэх	Амралтын дарга Ахлах нягтлан бодогч	Ж.Амарсүрэн Д.Цэцэгбаяр
12	ИНЕГ-ын харьяа <b>Сэргээн засах амралтын газар</b> өмнөх оны аудитаар өгсөн 11.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	11.1	Албан шаардлага хүргүүлэх	Амралтын дарга Ахлах нягтлан бодогч	Ж.Амарсүрэн Д.Цэцэгбаяр

13	<b>Буянт-Ухаа ОУНБ</b> -ын удирдлага авлагын дансанд 23 газрын 57.4 сая төгрөг, өглөгийн дансанд 68 байгууллагын 29.3 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	86.7	Албан шаардлага хүргүүлэх	Нисэх буудлын захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Ц.Цацрал
14	<b>Буянт-Ухаа ОУНБ</b> -ын удирдлага шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 221 мэдээллээс 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Нисэх буудлын захирал Нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Ц.Цацрал
15	<b>Баянхонгор аймаг дахь нисэх буудал</b> тайлант хугацаанд уурын зуухны халаалтын тогоо суурилсан боловч хуучин ашиглаж байсан 21.1 сая төгрөгийн үнэ бүхий халаалтын тогоог акталж данснаас хасах шийдвэр гараагүй боловч биетээр байхгүй байна.	21.1	Албан шаардлага хүргүүлэх	Аймгийн нисэх буудлын дарга Нягтлан бодогч	Ж.Ганхүлэг Д.Одончимэг
16	<b>Баянхонгор</b> аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр тус байгууллагын даргаар ажиллаж байсан ажилтанд ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлд 1.1 сая төгрөгийг зарцуулсан байна.	1.1	Албан шаардлага хүргүүлэх	Аймгийн нисэх буудлын дарга Нягтлан бодогч	Ж.Ганхүлэг Д.Одончимэг
17	<b>Баянхонгор аймаг дахь нисэх буудлын</b> удирдлага 2017 онд үүссэн ажиллагсадтай холбоотой 2.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэл ба өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар авлагыг барагдуулах талаар зөвлөмж өгсөн ч хэрэгжүүлээгүй байна.	2.9	Албан шаардлага хүргүүлэх	Аймгийн нисэх буудлын дарга Нягтлан бодогч	Ж.Ганхүлэг Д.Одончимэг
18	<b>Дорнод аймаг дахь нисэх буудлын</b> удирдлага шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 140 мэдээлэл оруулахаас 126 мэдээлэл оруулж 14 мэдээлэл хугацаа хоцроосон байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Аймгийн нисэх буудлын дарга Нягтлан бодогч	Ц.Юрабаатар Б.Бумчин
<b>Засгийн газрын тусгай сан</b>					
19	<b>Улсын авто замын сан</b> бие даасан шилэн дансны цахим хуудасгүй, яамны цахим хуудсанд давхар мэдээлдэг боловч зөвхөн замын сангийн дансны дугаараар харагдахаас "Улсын авто замын сан" нэрээр ил тод харагддаггүй, тайлант онд шилэн дансанд 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	-	Албан шаардлага хүргүүлэх	Захирал Нягтлан бодогч	Р.Буд Ц.Мөнхтуяа
20	<b>Автозамын норм нормативын сан:</b> Тайлант оны эцэст 6 аж ахуй нэгж байгууллагатай нийт 190.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан боловч дурдсан хугацаанд ажлыг хүлээлгэж өгөөгүй, гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй байна.	190.0	Албан шаардлага хүргүүлэх	Захирал БХЗММНН-ын дарга Нягтлан бодогч	Р.Буд Д.Базарсад Ц.Мөнхтуяа
21	<b>Автозамын норм нормативын сан:</b> Стандарт норм нормативыг хэвлэн олшруулахад 26.0 сая, шторк хийлгэхэд 16.0 сая төгрөгийн тус тус бараа, ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллаагүй байна.	42.0	Албан шаардлага хүргүүлэх	Захирал БХЗММНН-ын дарга Нягтлан бодогч	Р.Буд Д.Базарсад Ц.Мөнхтуяа
<b>Төрийн өмчит үйлдвэрийн газар</b>					

22	<b>МТЗ ТӨХК:</b> Зэвсэгт хүчний бүтээн байгуулалт дэмжлэгийн газарт олгосон урьдчилгаа дансны бүртгэл, тооцоо нийлсэн актын дүнгээс 609.5 сая төгрөг, хоорондын тооцооны өглөгийн үлдэгдэл, тооцоо нийлсэн актын дүнгээс 1,802.2 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй байна.	2,411.7	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал	Р.Батсүх
23	<b>МТЗ ТӨХК:</b> Жилийн эцэст 69 харилцагчтай 17,407.7 сая төгрөгийн өглөгийг тулган баталгаажуулаагүй, 43 харилцагчид төлөх өр төлбөрийн үлдэгдэл, тооцоо нийлсэн актын дүнгээс 13,813.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	20,589.2	Албан шаардлага хүргүүлэх	Ерөнхий нягтлан бодогч	Д.Даваадорж
24	<b>МТЗ ТӨХК:</b> 167.6 сая төгрөгийн өртөг бүхий бараа материалын худалдан авалтыг хэсэгчлэн гүйцэтгэж, шууд худалдан авалт хийсэн.	167.6	Албан шаардлага хүргүүлэх		
25	<b>МТЗ ТӨХК:</b> Бүрэн гүйцэтгэгдсэн төслийн ажлыг нэр төрлөөр капиталжуулалгүй, дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд хуримтлуулан бүртгэсэн, төслийн талбайд хүлээн авсан бараа материалын орлогын гүйлгээ, үйлдвэрлэлийн шат руу шилжүүлсэн зарлагын гүйлгээний баримт бүрдэл дутуу, бараа материалыг жилийн эцэст тоолж баталгаажуулаагүй зэргээр захиалагчийн зүгээс төслийн талбай дээрх өмч, хөрөнгөд тавих хяналт сул байна. Төслийн харилцах дансны зарлагын гүйлгээний үндэслэх баримтууд ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан УБТЗ-ын Төсөл хэрэгжүүлэх нэгж, ЗХЖШ-ын ББДГ-гаараас нэхэмжлэгдсэн, анхан шатны баримт бүрдэл дутуу байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх Захирал Ерөнхий нягтлан бодогч	Р.Батсүх Д.Даваадорж
26	<b>МИАТ ТӨХК</b> -ийн эрх бүхий албан тушаалтнууд “Зэт хорин дөрөв” ХХК-тай 2017 онд “Агаарын тээврийн зорчигчийн тийз борлуулалтын үйл ажиллагаа эрхлэн явуулах Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага байгуулах борлуулагч агентын гэрээний нэмэлт, өөрчлөлт” 17/332 тоот гэрээг байгуулж, борлуулалтын орлогоос авах 562.4 сая төгрөгийг барагдуулаагүйгээс авлагын хугацаа хэтэрч найдваргүй болох өндөр эрсдэлтэй байна.	562.4	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал Санхүү эрхэлсэн дэд захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Баттөр Н.Одмөнх Д.Батжаргал
27	<b>МИАТ ТӨХК:</b> Гүйцэтгэх захирлын Б/645 дугаар тушаалаар ажлаас үндэслэлгүй халагдсан нэр бүхий ажилтанд шүүхийн шийдвэрээр ажилгүй байх хугацааны нөхөн олговор 34.5 сая төгрөг олгохоос 20.0 сая төгрөгийг байгууллагаас олгосон байна.	20.0	Албан шаардлага хүргүүлэх	Зам, тээврийн хөгжлийн яам	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
28	<b>МИАТ ТӨХК</b> нь “Наран трейвэл” ХХК, “Mega Global Air Services Maldives private Limited”, “Ю Трэйвел” ХХК, “Эйр карго Монголиа” ХХК, Eastar jet Co.Ltd компаниудтай “Агаарын тээврийн зорчигчийн тийз борлуулалтын үйл ажиллагааг эрхлэн явуулах борлуулагч агент”-ын гэрээ, “Нойтон түрээс”-ийн гэрээ, “Захиалгат нислэг”-ийн гэрээ, “Техник үйлчилгээ хамтын ажиллагаа”ны гэрээг тус бүр байгуулж, гэрээний нөхцөл, үүргийг бүрэн хангуулж ажиллаагүйгээс нийт 5,020.7 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага он дамжин бүртгэгдэж, шүүх хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх ажиллагаа удаашралтай байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал Санхүү эрхэлсэн дэд захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Баттөр Н.Одмөнх Д.Батжаргал

29	<b>МИАТ ТӨХК</b> -ийн нислэгийн хэлтсийн Б737-800 агаарын хөлгийн 2-р нисгэгчээр ажиллаж байсан нэр бүхий ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ Берлин хотын “Adina” зочид буудалд 46,998.46 евро буюу 139.6 сая төгрөгийн хохирол учруулсныг “МИАТ” ТӨХК нь барагдуулж, авлага үүсгэн бүртгэсэн ба тус ажилтнаас буцаан авахаар гэрээ байгуулсан хэдий ч одоог хүртэл авлагыг барагдуулаагүй байна.	139.6	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал Санхүү эрхэлсэн дэд захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Баттөр Н.Одмөнх Д.Батжаргал
30	<b>МИАТ ТӨХК</b> нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоол “Шинэ коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”-ын 9 дүгээр хэсэгт “БНХАУ-ын Ухань хотод сурч байгаа Монгол иргэдээ татан авах тухай” заалтын дагуу 2020 оны 01 дүгээр сарын 31ний өдөр УБ-Ухань-УБ чиглэлд онцгой үүргийн нислэг гүйцэтгэхэд гарсан 57,950 ам доллар буюу 165.1 сая төгрөгийн зардлыг байгууллагаас гаргасан байна.	165.1	Албан шаардлага хүргүүлэх	ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга	С.Батболд Ж.Амгалан
31	<b>МИАТ ТӨХК:</b> Зам, тээврийн хөгжлийн яамны ажилтнууд болон нөлөө бүхий албан тушаалтнуудын онгоцны билетийн үлдэгдэл 14.2 сая төгрөг, мөн Батлан хамгаалах яамны “Газрын үйлчилгээ”-ний 230.0 сая төгрөг, нийт 244.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага он дамжин бүртгэгдсээр байна.	244.6	Албан шаардлага хүргүүлэх	ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга	С.Батболд Д.Ганхуяг
32	<b>МИАТ ТӨХК</b> нь Герман улсын /Lufthansa technik AG/ “Люфтханса техник” компанитай 1998 онд гэрээ байгуулсан байна. Гэрээг цуцлахдаа тухайн компанитай 293,544.47 ам доллар буюу 836.9 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүйгээс 2 талын хооронд маргаан үүсэж, өнөөг хүртэл шийдвэрлээгүй, авлага найдваргүй болох өндөр эрсдэлтэй байна.	836.9	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал Санхүү эрхэлсэн дэд захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Баттөр Н.Одмөнх Д.Батжаргал
33	<b>МИАТ ТӨХК</b> нь “Нүхт-Тур” ХХК-тай 2009 оноос эхлэн 09/131 дугаартай “Катерингийн төвийн удирдах үйл ажиллагааг гүйцэтгэх удирдлага”-ын гэрээг байгуулсан байна. Тус гэрээний 2 дугаар зүйлийн 2.1.3-т “Гэрээг хоёр жилийн хугацаатайгаар хоёр удаа сунгаж болно” гэж заасан боловч 2009 оноос хойш нийт 8 удаа гэрээг сунгасан байна. Мөн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар дээрх зөрчлийг арилгуулахаар удаа дараа албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжээгүй байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал Санхүү эрхэлсэн дэд захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Баттөр Н.Одмөнх Д.Батжаргал
34	<b>АТҮТ ТӨҮГ:</b> Өмнөх аудитын зөвлөмжөөр өгөгдсөн 4.7 сая төгрөгийн авлагыг тайланд хугацаанд барагдуулж ажиллаагүй байна.	4.7	Албан шаардлага хүргүүлэх	Захирал СЭЗХ-ийн дарга	Б.Гүрсоронзон Р.Баасандорж
35	<b>АТҮТ ТӨҮГ:</b> Үндэсний хөрөнгө оруулалтын банкин дахь үйл ажиллагааны орлогын харилцах дансны үлдэгдэл 262.6 сая, Чингис хаан банкны хадгаламжийн үлдэгдэл 14.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө арилжааны банкны үйл ажиллагаанаас шалтгаалан	277.0	Албан шаардлага хүргүүлэх	Захирал СЭЗХ-ийн дарга	Б.Гүрсоронзон Р.Баасандорж

	буцаан төвлөрүүлэхэд эрсдэлд орсон байна.				
36	<b>АТҮТ ТӨҮГ:</b> Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 65 дугаар магадлалаар 13.6 сая, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тухай 2020 оны 20/02-114 дүгээр тогтоолоор 6.0 сая төгрөг, нийт 19.6 сая төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий хоёр ажилтанд олгосон байна.	19.6	Албан шаардлага хүргүүлэх	Захирал СЭЗХ-ийн дарга	Б.Гүрсоронзон Р.Баасандорж
37	<b>АТҮТ ТӨҮГ:</b> Тайлант хугацаанд автомашины сэлбэг хэрэгсэлд 66.2 сая, урсгал засварын зардалд 51.4 сая, даатгалын үйлчилгээнд 27.1 сая, кино CD, фото мэдээлэл бэлтгэх, боловсруулахад 65.1 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг нэр төрөл, зориулалт, ижил төстэй байдлаар нь тодорхойлон худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд гэрээ байгуулсан байна.	209.8	Албан шаардлага хүргүүлэх	Захирал СЭЗХ-ийн дарга	Б.Гүрсоронзон Р.Баасандорж
38	<b>АТҮТ ТӨҮГ:</b> Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын орон тооны дээд хязгаарыг 819 байхаар баталсан боловч гүйцэтгэлээр 132 орон тоогоор илүү гэрээт ажилтан ажиллуулж, цалингийн зардалд 303.8 сая төгрөг зарцуулж, өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Захирал СЭЗХ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Гүрсоронзон Р.Баасандорж Б.Мөнхбаяр
39	<b>АТҮТ ТӨҮГ:</b> “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь харьяа 21 аймаг, 2 сум, 5 салбаруудын санхүүгийн тайлан бэлтгэж тайлагнахгүй байгаа зөрчлийг давтан гаргасан.	-	Албан шаардлага хүргүүлэх	Захирал СЭЗХ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Гүрсоронзон Р.Баасандорж Б.Мөнхбаяр
40	<b>АТҮТ ТӨҮГ:</b> Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд байршуулах нийт 3134 мэдээлэл байршуулахаас 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	-	Албан шаардлага хүргүүлэх	Захирал СЭЗХ-ийн дарга	Б.Гүрсоронзон Р.Баасандорж
41	<b>АТҮТ ТӨҮГ:</b> “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг төсвийн цаглаварт хугацаанаас 13 хоногоор хоцроож ирүүлсэн байна.	-	Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх	Захирал	Б.Гүрсоронзон
42	<b>СХД ТХҮТ:</b> Шилэн дансанд нийт 219 мэдээлэл байршуулахаас 204 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож, 7 мэдээллийг мэдээлээгүй байна. 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын гүйлгээнээс 69.7 сая төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	СХД ТХҮТ-ийн дарга Нягтлан бодогч	С.Давааням Э.Ганцэцэг
43	<b>ЗТХТ ТӨҮГ:</b> Тайлант хугацаанд нийт 28 ажилтанд аймаг, хот, сумдад албан томилолтоор ажиллаж байх хугацаанд хоол, унааны мөнгө давхардуулан 11.7 сая төгрөгийг илүү олгосон.	11.7	Албан шаардлага хүргүүлэх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Р.Буд Б.Дуламханд
44	<b>ЗТХТ ТӨҮГ:</b> Шилэн дансны цахим хуудсанд 146 мэдээлэл байршуулахаас хугацаандаа оруулсан 129 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 14 мэдээлэл, 1 мэдээллийг байршуулаагүй байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Р.Буд Б.Дуламханд



45	“Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХК: Тайлант хугацаанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 161 мэдээлэл, хугацаа болоогүй 1 мэдээлэл, хугацаа хоцроосон 9 мэдээлэл байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал Нягтлан бодогч	Л.Цэнгүүнжав Ё.Мөнхбаяр
46	“Далайн захиргаа” УТҮГ: Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 орлогын 73.2 сая төгрөгийн гүйлгээний мэдээллийг байршуулаагүй байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Дарга Нягтлан бодогч	С.Түвшинтөр П.Мөнхбат
47	“Багануур АЗЗА” ТӨХК: Санхүүгийн тайлангийн тусгасан төрийн өмчийн хэмжээ нь улсын бүртгэлийн гэрчилгээний болон компанийн дүрэмд тусгасан хэмжээнээс зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Захирал Ерөнхий нягтлан	А.Алтангадас А.Сарантуяа
48	“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгасан.	13.4	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Ерөнхий санхүүч түр орлон гүйцэтгэгч	Н.Пүрэвсүрэн О.Уранчимэг
49	“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК: Бараа материалын хөдлөл өөрчлөлтийг материалын дансаар дамжуулаагүй шууд зардлаар тайлагнасан.	1.6	Албан шаардлага хүргүүлэх		
50	“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК: Шилэн дансны мэдээлэл дутуу тусгасан.	-	Албан шаардлага хүргүүлэх		
51	“Орхон АЗЗА” ТӨХК: Анхан шатны баримтын бүрдэл дутуу 6.2 сая төгрөгийн гүйлгээг бүртгэсэн.	6.2	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Ц.Батзориг Т.Батдорж
52	“Орхон АЗЗА” ТӨХК: Цалин хөлсний зардлаас 7.3 сая төгрөгийг илүү олгосон.	7.3	Албан шаардлага хүргүүлэх		
53	“Орхон АЗЗА” ТӨХК: Шилэн дансны мэдээллийг байршуулаагүй байна.	-	Албан шаардлага хүргүүлэх		
54	“Өвөрхангай АЗЗА” ТӨХК: Орлогын 9.8 сая төгрөгийн 1 удаагийн, зарлагын 8.8 сая төгрөгийн 1 удаагийн гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал Ерөнхий санхүүч	Д.Лхам-Оролмаа С.Төмөрбаатар
55	“Налайх АЗЗА” ТӨХК: Шилэн дансны хуулийн дагуу шалгахад нийт 127 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 122, хоцорсон 3, хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Ц.Баттулга Ц.Наранцэцэг
56	“Хархорин АЗЗА” ТӨХК: Шилэн дансны мэдээлэлд 85.3 сая төгрөгийн гүйлгээг дутуу тусгасан.	-	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал Ерөнхий Нягтлан бодогч	Ж.Бадрах М.Сувдхорол
57	“Булган АЗЗА” ТӨХК: ХАА-ны босго үнэ давсан 3 төрлийн бараа үйлчилгээг худалдан авахад 169.8 сая Хутаг-Өндөр суманд ажилчдын байрыг шилжүүлэн засварлахад 15.0 сая төгрөг тендер зарлаагүй шууд гэрээ байгуулсан.	184.8	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал	Э.Пүрэвдэмбэрэл Г.Цэцэгмаа
58	“Булган АЗЗА” ТӨХК: Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Ерөнхий нягтлан бодогч	
59	“Булган АЗЗА” ТӨХК: Өмнөх оны зөвлөмж авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	-	Албан шаардлага хүргүүлэх		
60	“Булган АЗЗА” ТӨХК: Үндсэн хөрөнгийн тавилга хэрэгслийн ангилалд тоног төхөөрөмж ангилан бүртгэсэн.	30.0	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал	Э.Пүрэвдэмбэрэл

61	“Булган АЗЗА” ТӨХК: Аж ахуйн материалын дансанд үндсэн хөрөнгийг ангилж бүртгэсэн.	18.2	Албан шаардлага хүргүүлэх	Ерөнхий нягтлан бодогч Тооцооны ня- бо Нярав	Г.Цэцэгмаа Д.Бурмаа Ц.Батжаргал Ш.Отгонцэцэг
62	“Булган АЗЗА” ТӨХК: Тайлант онд ТУЗ-ийн шийдвэргүйгээр иргэд, аж ахуй нэгж 184.2 сая төгрөгийн зээл авч хүүд 22.3 сая төгрөг төлж бүрэн эрхийг хэтрүүлсэн.	206.5	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал	Э.Пүрэвдэмбэрэл Г.Цэцэгмаа
63	“Булган АЗЗА” ТӨХК: Тайлант онд нярвын хувийн дансаар гүйлгээ хийгдсэн.	168.0	Албан шаардлага хүргүүлэх	Ерөнхий нягтлан бодогч	
<b>Төсвийн шууд захирагч</b>					
64	<b>ЗТХЯ:</b> Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 90 дүгээр магадлалаар албан тушаалд эгүүлэн томилогдсон албан хаагчид ажилгүй байсан хугацааны 30.3 сая төгрөгийн цалинг цалингийн сангаас олгоходоо буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй.	30.3	Албан шаардлага хүргүүлэх	ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга  Ерөнхий нягтлан бодогч нягтлан бодогч	С.Батболд Г.Алтангэрэл О.Очгэрэл
65	<b>ЗТХЯ:</b> Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг зөрчин улирал бүрийн үр дүнгийн урамшууллаас гадна жилийн эцсийн урамшууллыг 124 албан хаагчид 159.4 сая төгрөгийн, мөн бусад шагнал урамшууллыг хавтгайруулан олгосон.	159.4	Албан шаардлага хүргүүлэх	ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга  Ерөнхий нягтлан бодогч нягтлан бодогч	С.Батболд  Г.Алтангэрэл О.Очгэрэл
66	<b>ГТХЗТ:</b> Шилэн дансны 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	-	Албан шаардлага хүргүүлэх	Захирал Нягтлан бодогч	А.Буяннэмэх С.Золзаяа
<b>Дүн</b>		<b>30,409.3</b>			



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 04 дугаар сарын 26

№ 112/АОН10001

Улаанбаатар хот

САГ-2021/000/СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Автоимпекс” ХК нь 2020 оны санхүүгийн тайланд бүртгэлтэй ногдол ашгийн өглөг 11,525,471.31 /арван нэгэн сая таван зуун хорин таван мянга дөрвөн зуун далан нэгэн / төгрөг гучин нэгэн мөнгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д “Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.5.1-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.1-д зааснаас бусад төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Улсын төсөвт төвлөрүүлээгүй ногдол ашгийн төлбөр 11,525,471.31 /арван нэгэн сая таван зуун хорин таван мянга дөрвөн зуун далан нэгэн / төгрөг гучин нэгэн мөнгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх, актын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН!**

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

001090187



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 561/20110001  
СЭГ-0001/04/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Иргэний нисэхийн ерөнхий газарт Үндэсний аудитын газраас 2018, 2019 онд өгсөн гадаадын болон дотоодын авиа компаниудаас авах хугацаа хэтэрсэн, тооцоо нийлсэн актгүй нийт 2,476,978.4 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа талаарх албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдах этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэх, тооцоог хянан баталгаажуулах, авлага барагдуулах арга хэмжээг зохион байгуулж ажиллах, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

 Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

10.10.10.20.Bichig\_Khereg:Alban\_Shaardlaga\2021\0425auditin 2-R\_Gazar1.Docx

001081986



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 562/АОН0001

Улаанбаатар хот

САГ- 2021/24/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд нийт 10851 мэдээлэл байршуулахаас 1053 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, мөн цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 227,265.5 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээний шийдвэрийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-д заасныг үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

  
Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2021 оны 04 дугаар сарын 22

№ 110/А0170067

Улаанбаатар хот

СТГ-2021/200/СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Зам, тээврийн хөгжлийн яамны хөрөнгө оруулалтын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд 2013 онд автозамын материалын үнийн өсөлтийн зөрүү олгосноос хэмнэгдсэн 195,549,246.00 /нэг зуун ерэн таван сая таван зуун дөчин есөн мянга хоёр зуун дөчин зургаан/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Барьцаа хөрөнгийн дансанд байршсан 195,549,246.00 /нэг зуун ерэн таван сая таван зуун дөчин есөн мянга хоёр зуун дөчин зургаан/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх, актын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, нягтлан бодогч О.Очгэрэл нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15 № 393/А017-0067  
САГ - 2021/7/СТА-Т04Г  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "МИАТ" ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоол "Шинэ коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай"-ын 9 дүгээр хэсэгт "БНХАУ-ын Ухань хотод сурч байгаа Монгол иргэдээ татан авах тухай" заалтад шаардагдах зардлыг тусгаж өгөөгүй тул "МИАТ" ТӨХК нь Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоолыг биелүүлж, 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Улаанбаатар-Ухань-Улаанбаатар чиглэлд онцгой үүргийн нислэг гүйцэтгэн Монгол иргэдээ авахад 57,950 ам доллар буюу 165,129,104.50 /нэг зуун жаран таван сая нэг зуун хорин есөн мянга нэг зуун дөрвөн/ төгрөгийн зардлыг гаргасан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоолыг хэрэгжүүлж онцгой үүргийн нислэг гүйцэтгэхэд зарцуулсан 165,129,104.50 /нэг зуун жаран таван сая нэг зуун хорин есөн мянга нэг зуун дөрвөн/ төгрөгийн зардлыг "МИАТ" ТӨХК-д буцаан олгох арга хэмжээ авч, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд, хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга хурандаа Ж.Амгалан нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР  
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.БОЛОР-ЭРДЭНЭ  
Л.БОЛОРЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2021\031Sauditin 2-R\_Gazur152.Docx

001080578



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 374/А0170067

Улаанбаатар хот

САГ - 2021/7(СТА - ТӨЧГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "МИАТ" ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зам, тээврийн хөгжлийн яамны эрх бүхий албан тушаалтнуудын онгоцны билетийн үлдэгдэл төлбөр 14,289,200.00 төгрөг, мөн Батлан хамгаалах яамны "газрын үйлчилгээ"-ний 230,000,000.00 төгрөг, нийт 244,642,745.50 /хоёр зуун дөчин дөрвөн сая зургаан зуун дөчин хоёр мянга долоон зуун дөчин таван/ төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага он дамжин бүртгэгдсээр байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6-д "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрх бүхий албан тушаалтнуудын онгоцны билетийн үлдэгдэл төлбөр болон газрын үйлчилгээний төлбөр нийт 244,642,745.50 /хоёр зуун дөчин дөрвөн сая зургаан зуун дөчин хоёр мянга долоон зуун дөчин таван/ төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Батлан хамгаалах яамны төрийн нарийн бичгийн дарга хурандаа Д.Ганхуяг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР  
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР

*(Handwritten signatures)*

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Л.БОЛОРЦЭЦЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 370/А017-0067

Улаанбаатар хот

САГ - 2021/7/СТА - ТӨҮГ  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "МИАТ" ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын Б/645 тоот тушаалаар ажлаас үндэслэлгүй халагдсан нэр бүхий ажилтанд шүүхийн шийдвэрээр ажилгүй байх хугацааны нөхөн олговор 34,469,882.00 төгрөг олгохоос 20,000,000.00 /хорин сая/ төгрөгийг байгууллагаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлаас үндэслэлгүй халагдсан нэр бүхий ажилтанд нөхөн олговорт олгосон 20,000,000.00 /хорин сая/ төгрөгийн төрд учруулсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, компанийг хохиролгүй болгох арга хэмжээг авах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Л.БОЛОРЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 497/А0170067.

Улаанбаатар хот

САГ-2021/357/СТА-ТШБ.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Автозамын норм нормативын сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст 6 аж ахуй нэгж байгууллагатай нийт 190,025.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан боловч дурдсан хугацаанд ажлыг хүлээлгэж өгөөгүй, гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 142 дүгээр тушаалаар баталсан "Автозамын норм нормативын сангийн ажиллах журам"-ын 2.8.2-т "Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичгийг боловсруулах дарааллыг тогтоох санал оруулах, сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авто зам, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичиг боловсруулах гэрээнд холбогдох нөхцөлийг нарийн тусгаж байх, гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, биелэлтийг тооцон, сангийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөж зарцуулах, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын захирал Р.Буд, нягтлан бодогч Ц.Мөнхтуяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 498/00170067.

Улаанбаатар хот

САГ-2021/354/СЭВ-ТМЗ.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Автозамын норм нормативын сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Стандарт норм нормативыг хэвлэн олшруулахад 26,000.0 мянга, шторк хийлгэхэд 16,000.0 мянган төгрөгийн тус тус бараа, ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 34 дүгээр зүйлийн 34.1-т "Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараахь нөхцөлд хэрэглэж болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын захирал Р.Буд, нягтлан бодогч Ц.Мөнхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ